



M

ОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2019 • V • № 32



ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn



Mongolbankmn



*Хөгжилд түргээлсэн
95 жил*

Эрхэм Танаа



Монгол Улсад орчин цагийн банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойн баярыг тохиолдуулан банкны салбарын үе үеийн ажилтнууд болон нийт олон түмэн Та бүхэнд чин сэтгэлийн мэндчилгээг өргөн дэвшүүлье!

Хэдийгээр Монгол Улсад банк санхүүгийн салбар үүсч хөгжсөн нь зуун жилийн босгонд ойртож байгаа ч монголчууд бидний санхүүгийн харилцааны түүх үүнээс ч өнө эртнийх юм. .

Түүхэн эх сурвалжуудыг нэхэн үзвэл Хүннү гүрний үед зоосон мөнгө хэрэглэж байсан бол Чингис хаан, түүний залгамжлагчид алт, мөнгөн зоос цутгуулж, цаасан тэмдэгт хэвлүүлж, гүйлгээнд гаргаж, Мөнх хааны үед цаасан болон зоосон мөнгөний хэмжээг хянах тусгай хороог ажиллуулж байжээ. Хубилай хааны үед Хархорум хотод мөнгө тушаах газар байгуулж, олон төрлийн дэвсгэрт бүхий мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулж, мөнгөн гүйлгээний ажил эрхлэх салбаруудыг байгуулж байв.

Энэхүү баялаг уламжлал нь эзэнт гүрний задрал, Манж Чин улсын нөлөөнд дэх он жилүүдэд саатаж бүдгэрсэн ч монголчууд бие даасан санхүүгийн бодлоготой болохыг эрмэлзсээр 1921 оны Ардын хувьсгалын дараа орчин цагийн Монголын санхүүгийн тогтолцооны суурь тавигдах нөхцөл бүрдсэн юм.

Монгол Улсын Засгийн газрын 1922 оны 3 дугаар сарын 27-28-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу Зөвлөлт-Монголын хувь нийлүүлсэн Худалдаа ба аж үйлдвэрийн банк буюу Монголбанкийг 1924 оны 6 дугаар сарын 2-нд Нийслэл хүрээнд байгуулжээ. Тус банк 250'000 алтан рублийн дүрмийн сантай, 22 орон тоотой байгуулагдаж байв. Ийнхүү үндэсний банк байгуулагдсанаар Монголд орчин цагийн мөнгөн гүйлгээний тогтолцоо үүсэн бэхжих, үндэсний мөнгөн тэмдэгтэй болох, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах суурь тавигдав.

1920-иод онд мөнгөний шинэчлэлт хийж, Монголын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг гүйлгээнд гаргаж, худалдаа бэлтгэлийн ажиллагааг санхүүжүүлж, зах зээлийн барааны хангамж, үнийн хөдөлгөөнийг зохицуулж, ардын аж ахуйтанд зээл олгож байсан нь Монголбанкны үндсэн үйл ажиллагаа болж байлаа. Тухайлбал, БНМАУ-ын Их хурлын шийдвэрийг үндэслэн Засгийн газраас 1925 оны 2 дугаар сарын 22-нд мөнгөний шинэчлэл явуулах тухай тогтоол гаргаж, Монголын үндэсний мөнгөний нэгжийг “төгрөг” хэмээн нэрлэж, үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах эрхийг Монголбанкинд олгожээ. Иймд 1925 оны 12 дугаар сарын 9-ны өдөр Монголбанк үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийг 1, 2, 5, 10, 25, 50, 100-тын дэвсгэртээр гүйлгээнд гаргаж мөнгөний эргэлтийн эмх замбараагүй байдлыг зогсоож, олон төрлийн мөнгөөр гүйлгээ хийх явдлыг хязгаарлаж байв.



1954 онд Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ) Монголбанкинд байршуулсан өөрийн хувь хөрөнгө (50 хувь) Монголын талд шилжүүлснээр Улсын Банкны Ерөнхий Хороо нь Засгийн газрын харьяанд үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. 1991 онд Банкны тухай хууль батлагдсанаар Монгол Улсад хоёр шатлалт банкны тогтолцоо хөгжих эрх зүйн болон зохион байгуулалтын үндсийг тавьж, банкны тогтолцоо нь төв банк болон арилжааны банкнаас бүрдэхээр болов. Үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилт бүхий төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, эмиссийн үйл ажиллагаа явуулах, арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих, улсын валютын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх, үүргийг Монголбанк (төв банк)-нд ногдуулж, арилжааны банкууд бие даасан үйл ажиллагаа явуулж эхэлсэн билээ.

Өнгөрсөн 95 жилд банк, санхүүгийн салбар олон улсын түвшинд хүртлээ хөгжиж, гүйцэтгэх үүрэг нь нэмэгдэж, улс орны бүтээн байгуулалт, нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж ирлээ. Монголбанк нь байгуулагдсан цагаас эхлэн банк, санхүүгийн системийг хөгжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтийг хангах, эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг нэмэгдүүлэх, үндэсний мөнгөн тэмдэгтийг олон улсын стандартад нийцүүлэн гаргах, гадаад валютын улсын нөөцийг удирдах, төлбөр тооцооны системийг хөгжүүлэх зэрэг олон чиглэлээр улс орны хөгжилд эерэг өөрчлөлтүүдийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэв.

Монголбанк сүүлийн 3 жилийн хугацаанд улс орны эдийн засгийг сэргээх, улсын өрийн дефолтоос зайлсхийх, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, дархлааг сэргээх, банк санхүүгийн салбарыг эрүүл байлгах, Монголбанкийг орчин үеийн төв банкны жишигт хүргэн чадваржуулахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулж, тодорхой үр дүнд хүрсээр байна. Эдгээрээс дараах 5 онцлох үр дүнг энд товч дурдъя.

Нэг. Санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийг эхлүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиг үүргээ амжилттай хэрэгжүүлж байна. Банкны салбарын тулгуур хуулиуд болох Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлын тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Мөнгө

угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зэрэг санхүүгийн салбарын суурь багана болсон эрх зүйн актуудыг боловсронгуй болгох үүднээс нэмэлт өөрчлөлтийн төслийг эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулж, УИХ-аар батлуулаад байна.

Хоёр. Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т орох, орсны дараах үүрэг амлалтаа амжилттай хэрэгжүүлэн эдийн засгийн сэргэлтэд бодит хувь нэмэр оруулж байна. 2017, 2018 онд эдийн засагт тулгарч байсан олон сорилтыг амжилттай даван туулж, эдийн засаг сэргэсэн, банк санхүүгийн салбарт реформ хийсэн шинэчлэлийн жилүүд болж өнгөрлөө. Энэ оны эхний улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 8.6 хувьтай, инфляци зорилтот түвшний орчим тогтвортой байна. Эдийн засагт гарсан нааштай, эерэг нөхцөл байдалд тулгуурлан зээлийн хүүг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү сүүлийн 6 жилийн хамгийн бага түвшинд хүрээд байна.

Гурав. Монголбанкны өөрийн хөрөнгө (хуримтлагдсан алдагдал) -3 их наяд төгрөг байсныг сүүлийн 2 жилд 1.2 их наяд төгрөгөөр бууруулж, цаашид эерэг болгох зорилт тавин ажиллаж байна. Бидний тооцоогоор одоо баримталж буй зарчим, үйл ажиллагаагаа цаашид хадгалан ажиллавал Монголбанк 2019 болон 2020 онд үргэлжлүүлэн ашигтай ажиллах бөгөөд өөрийн хөрөнгийг эерэг болгохын төлөө ажиллаж байна.

Дөрөв. Гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийн хэмжээг 2016 оныхоос 4 дахин нэмэгдүүлж 3.8 тэрбум ам.долларт хүргэж чадлаа. Монголбанк Засгийн газраас хэрэгжүүлж буй Алт-2 хөтөлбөрт дэмжлэг үзүүлэн ажиллаж, алтны салбарын хууль эрх зүйн орчныг шинэчлэх, алтыг орон нутаг худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах, энэ хүрээнд алтны сорьцын лабораторийг Дархан-Уул, Баянхонгор аймагт байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгээд байна. Монголбанк 2016 онд 18.6 тонн, 2017 онд 20 тонн, 2018 онд 22 тонн үнэт металл худалдан авч, энэ эх үүсвэрээс жил бүр 700-800 сая ам.доллараар Монгол Улсын ГВАН-ийг нэмэгдүүлэв. Түүнчлэн томоохон экспортлогч компаниудтай хэлцэл хийх замаар гадаад валютыг худалдан авч, гадаад валютын нөөцийг арвижуулав. Энэ нь тийм ч амар ажил байгаагүй.



Тав. Монголбанкны дотоод үйл ажиллагаанд шинэчлэлт хийж, орчин үеийн төв банкны жишигт хүргэхээр ажиллаж байна. Монголбанкны бүтэц, зохион байгуулалтыг олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн шинэчилж, чадварлаг залуу удирдлагын багийг бүрдүүлэн хүний нөөцийн бодлогыг боловсронгуй болгон ажиллалаа. Үүний зэрэгцээ Монголбанкны ажилтнуудын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах чиглэлд анхаарч байна. Сүүлийн жилүүдэд анхаарлаас хөндий байсан Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааг сэргээж, Монгол Улсын Эрдэнэсийн сан ном гаргаж, хосгүй үнэт эрдэнэсийн сангийн үзвэрээс бүрдсэн музей болгон тохижуулж нийтэд нээлттэй болголоо.

Эдийн засгийн цаашдын төлөвийг авч үзвэл эдийн засгийн сэргэлт үргэлжилж, өсөлт 2018 оны түвшнээс буурахгүй байх, инфляци зорилтот түвшний орчим хадгалагдах төлөв харагдаж байна. Гэхдээ эдийн засагт томоохон сорилтууд тулгарсан хэвээр, бидэнд хийх ажил их байна. Өмнө тулгарч байсан сорилтуудыг бид хамтын хүчээр амжилттай даван туулж, Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, хөгжилд хөтөлнө гэдэгтээ итгэл төгс байна.



Монголбанк Монгол Улсын эдийн засагт гарч буй эерэг өөрчлөлтийг бататгах, эдийн засгийн өсөлтийг нийт ард иргэд, бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй болгох, банкны салбарыг хүчирхэг болгох үндсэн чиг үүргээ амжилттай үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, өмнө тулгарч буй сорилтуудыг амжилттай даван туулахад шаардлагатай бүхий л арга хэмжээг эрх бүхий байгууллагуудтай хамтран цаг тухайд нь авч хэрэгжүүлнэ.



Төв банкны нээлттэй, ил тод болон бие даасан, хариуцлагатай байх зарчмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд эдийн засгийн тогтвортой байдал, ирээдүйн өсөлт хөгжлийн чухал тулгуур болсон реформ, шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх ажлыг цаашид үргэлжлүүлэх болно.

Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөн 95 жилийн түүхийг бүтээлцсэн, шинэ бүхний манлайд зүтгэж, гар бие оролцож ирсэн хүндтэй эрхмүүд, үе үеийн банкирууд Та бүхэнд талархал илэрхийлж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөг үлэмж бэхжиж, эрдэнэсийн сан цаашид улам өргөжин баяжиж, банкны салбар хүчирхэгжин хөгжих болтугай!

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.БАЯРТСАЙХАН







1995

"Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хагаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль" —ийг батлуулж, банкны харилцагчдын эрхийг хамгаалав.

1993

Тогтмол ханшийн дэглэмээс валютын чөлөөтэй хөвөх тогтолцоонд шилжив.

2001

Монголбанкны дүрмийн санг 4 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэв.

2007

Инфляцийг онилох мөнгөний бодлогын арга, хэлбэр рүү шилжиж эхлэв.

1998

Мөнгөжсөн алт, үнэт металлын бүртгэлийн үнийг тогтоов.

2004

Эрдэнэсийн сангийн үзмэрийг шинэчлэн дэглэв.

1994

Мөнгөний үзүүлэлтүүдийг онилсон арга хэлбэрт шилжэв.

1999

"Master" олон улсын төлбөрийн картын сүлжээнд холбогдов.

2005

Төлбөр тооцооны Үндэсний цахим гүйлгээний төвийг байгуулав.



1996

Олон улсын төлбөр тооцооны найдвартай, шуурхай байдал хангагдав.

2002

Интернет банкны үйлчилгээг анх нэвтрүүлэв.







ЭРТНИЙ ЗООСНООС Ө Н Ө Ө Г И Й Н ТӨГРӨГ ХҮРТЭЛ

Монгол туургатан Хүннү, Сүннү, Түрэг, Уйгар, Кидан гүрний үеэс зоосон мөнгийг хэрэглэж, таваар, мөнгөний гүйлгээг харьцангуй өндөр түвшинд эрхлэн явуулж байжээ. Түүнээс хойш Их Монгол Улсыг байгуулсан Чингис хаан өөрийн эзэлсэн улс, гүрнүүдэд алт, мөнгөн зоос дэлдүүлж, гүйлгээнд гаргадаг байсан бол Хубилай хааны үед 1227 онд дэлхийд анх удаа цаасан мөнгөн дэвсгэртэйг гүйлгээнд нэвтрүүлж байсан түүхтэй. Үүгээр зогсохгүй 1253 онд "Мөнгөний хэрэг эрхлэх хэлтэс" нэртэй мөнгөн гүйлгээ эрхэлсэн байгууллага буюу одоогийнхоор "банк" байгуулан ажиллуулж байсан эх сурвалж бий. Монголын эзэнт гүрний хаанчлалын үед 200 гаруй төрлийн алт мөнгөн болон металл зоос дэлдүүлж мөн цаасан тэмдэгтүүдийг гүйлгээнд гарган хэрэглэж байв.

Их хаадын
үеийн зоос



XVII зууны сүүлчээр Халх Монгол Манжийн эрхшээлд орсон үеэс хятад худалдаачид гадаад монголд нэвтэрч, хятадын худалдаа арилжаа дэлгэрч, ард олон голдуу зээлээр худалдаа хийдэг байсан нь монголчууд тэр чигтээ шахуу өрийн сүлжээнд орсон байв. Тэр үед малын түүхий эдээр бараа таваар солилцохоос гадна мөнгөний нэгжийн үүргийг мөнгөн ембүү, цай ч бас гүйцэтгэж байв. Учир нь монголд хамгийн их гүйгддэг бараа нь цай байсан тул цайг ууж хэрэглэхээс гадна мөнгөний оронд эд таваар үнэлэхэд хэрэглэдэг байв.



Юань
гүрний
цаасан
мөнгөн
тэмдэгт

Хунз
цай



1860-1870-аад оны үед Монголд орон нутгийн чанартай цаасан мөнгөн тэмдэгт хэрэглэж байжээ. Тухайлбал, Чин сүжигт Номун ханы хүрээнд өөрийн шавийн нутагт гүйлгэхээр нэг шар цай, арван шар цай гэсэн хоёр янзын үнэлгээтэй "Их сангийн тийз" хэмээх

цаасан мөнгийг гэгээний сангаас гаргаж байжээ. 1917, 1918 оны үеэр энэхүү мөнгөн тэмдэгтийг тав дахь удаагаа хэвлэж, орон нутаг дотроо чөлөөтэй хэрэглэж байсан тухай мэдээ бий. XIX зууны сүүлээр орос, хятад худалдаачид жингийн мөнгө, мөнгөн зоосыг оруулан ирж хэрэглэснээр Монголд таваар мөнгөний харилцаа шинэ шатанд гарч эхэлжээ.





Их сангийн
туйз



XVII-XX зууны эхэн үеийн Монгол Улсад үндэсний мөнгөн тэмдэгт, банк, зээлийн үндэсний тогтолцоо алга байв. 1895 онд Орос, Хятадын банк байгуулагдаж, салбараа Хүрээ, Улиастайд байгуулж байжээ. Хятадын Засгийн газар Ар Монголын автономит засаглалыг халснаар 1918 онд Хятадын банкийг хааж, Хязгаарын банк байгуулсан байна. Харин 1924 онд Монгол-Зөвлөлтийн "Худалдаа, аж үйлдвэрийн банк (Монголбанк)" байгуулагдсанаар үндэсний мөнгөн тэмдэгтэй болж, орчин үеийн банкны салбарын эхлэл, мөнгөний бодлогын суурь тавигджээ.



Орос –Монголын хамтарсан МХАУБ байгуулах тухай Ардын Засгийн газрын хуралдааны бичиг, 1924.02.

Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Банк (МХАУБ)–ны анхны байр, 1924 он



Монгол Улс албан ёсоор анх 1925 оны 12 дугаар сарын 9-нд 200100 төгрөгийг гүйлгээнд гаргажээ. Харин энэ үед Хятадын янчаан нь хууль ёсны төлбөрийн хэрэгслийн үүргийг гүйцэтгэж, улсын төсвийн орлого, зарлага, үйлдвэр, аж ахуйн газар, банкны бүртгэл тооцоог түүгээр хөтөлж байснаас эхэн үедээ төгрөгтэй зэрэгцэн гүйлгээнд хэрэглэгдэж байв. Засгийн газар Төв банкнаас үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах бэлтгэл ажлыг далайцтай зохион байгуулж, мөнгөн тэмдэгтийн ач холбогдлыг өргөн сурталчилж, мөнгөний

шинэчлэлт хийхэд онцгой анхаарал тавьж байсан бөгөөд, үүнийг хэр амжилттай хэрэгжүүлснээс эдийн засгийн бусад арга хэмжээний үр дүн шалтгаалах ёстой байв. Төгрөгийн нэр хүнд, эзлэх жин нь түргэн өсч, анх хятадын 0.88 янчаантай тэнцүү байсан нэг төгрөг нь жилийн дараа гэхэд нэг янчаантай тэнцэх болсон нь шинэ мөнгөн тэмдэгт зах зээлд амжилттай нэвтэрснийг харуулж байна. Ингэж шинэ мөнгөн тэмдэгт "төгрөг" зах зээл дээр ноёлох чанартай үндсэн валют болон хувирчээ.

Улсын алт болон валютын фондод түшиглэн 1928 оны 4 дүгээр сарын 15-наас төгрөгийг алтан баталгаанд оруулсан байна. Ингэснээр БНМАУ-ын үндэсний валют "Төгрөг" бат найдвартай валют болох үндэс тавигдаж 1928 оны 8 дугаар сарын 1 гэхэд төгрөг нь албан ёсны алтан баталгаанд орж 51.8 америк центтэй тэнцэх болжээ. Үүгээр мөнгөний шинэчлэлтийн ажил үндсэндээ цэгцэрч, шинэ валют төгрөг нь хууль ёсны бат бэх нэгж болж чаджээ.



МОНГОЛБАНКНЫ ҮЕ ҮЕИЙН УДИРДЛАГУУД

Монгол Оросын хамтарсан Худалдаа, аж үйлдвэрийн банк анх байгуулагдсан 1924 оноос 1931 он хүртэл орос мэргэжилтнүүд болох В.И.Комар, Д.И.Микилман, Н.И.Дойчман нар удирдсан байдаг. Харин 1931 онд Худалдаа, аж үйлдвэрийн банкны анхны Монгол даргаар С.Довчин томилогдож, 1931-1939 он хүртэл 8 жил ажиллажээ. Түүнээс хойших хугацаанд Монголбанкийг Ю.Цэдэнбал, Т.Балдан, Г.Балжид, Л.Лхамсүрэн, П.Төмөр, Д.Данзан, Г.Хүдэрчулуун, Н.Жаргалсайхан, Д.Моломжамц, Ж.Үнэнбат, О.Чулуунбат, А.Батсүх, Л.Пүрэвдорж, Н.Золжаргал, Н.Баяртсайхан нарын хүмүүс удирдаж, төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх түвэг бэрхшээлтэй боловч түүхэн гавьяатай албыг залгуулж байна.



В.И.КОМОР
(1924-1925)



Д.И.МИХЕЛЬМАН
(1925-1927)



Н.И.ДЕЙЧМАН
(1927-1928)



В.И.ФЕСЮК
(1928-1931)



С.ДОВЧИН
(1931-1939)



Ю.ЦЭДЭНБАЛ
(1939-1940)



Т.БАЛДАН
(1940-1955)



Г.БАЛЖИД
(1955-1960)



Л.ЛХАМСҮРЭН
(1960-1965)



П.ТӨМӨР
(1965-1975)



Д.ДАНЗАН
(1975-1981)



Г.ХҮДЭРЧУЛУУН
(1981-1991)



Н.ЖАРГАЛСАЙХАН
(1991-1992)



Д.МОЛОМЖАМЦ
(1992-1996)



Ж.ҮНЭНБАТ
(1996-2000)



О.ЧУЛУУНБАТ
(2000-2006)



А.БАТСҮХ
(2006-2009)



Л.ПҮРЭВДОРЖ
(2009-2012)



Н.ЗОЛЖАРГАЛ
(2012-2016)



Н.БАЯРТСАЙХАН
2016 оноос



ҮНДЭСНИЙ БАНК ҮҮСЭЖ БЭХЭЖСЭН НЬ

- 1910 он:** Орос болон бусад улстай хамтарсан банк байгуулахыг эрмэлзэж байсан ч хэрэгжиж хараахан амжаагүй.
- 1912 он:** Нийслэл хүрээнд түр банк байв.
- 1912 он:** 7-р сард Ардын засгийн газраас бүх аймаг хошуу, шавийн албаны өр шир төлөх, шинээр өр тавихыг зогсоосон шийдвэр гаргав.
- 1915 он:** Оросын эзэнт гүрний өмчлөл бүхий “Монголын үндэсний банк” нэртэй банкиг Нийслэл хүрээнд нээсэн ч удаагүй.
- 1918.10.14** Гэрээ ёсоор Жиу Хэү Юн Шан хэмээх Хятад банкны салбар Хүрээнд нээгдэв.

1921.04.20-10 сарын 20 хүртэл 6 сарын хугацаатай Бага болзоот хэмээн нэрлэсэн цаасан мөнгө гүйлгээнд гаргав.

1921.07 сард Монгол Улсын сангийн яам 3.5 сая долларын цаасан мөнгийг шинээр хийлгэсэн нь өдгөө Данзангийн доллар гэгддэг бөгөөд гүйлгээнд гараагүй.

1922 он: МУЗГ банк байгуулахтай холбоотой асуудлыг удаа дараа хэлэлцэж, 2 сарын 28 нд Монгол Улсын Дотоод Яаманд хуралдсан Түр цагийн хурлаар “Сангийн яамны илэрхийлэн гаргасан Улсын хоршоо сайжруулах банк нээх” нь зүйтэй гэж үзжээ.

ХОЁР ШАТЛАЛТ БАНКНЫ ТОГТОЛЦОО

- 1990 он:** Арилжааны банк байгуулах эхлэл тавигдав. БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1990.08.24-ны 422-р тогтоолоор Аж ахуйн банк байгуулах болон нийтлэг дүрмийг нь батлав.
- 1990.09.30** Монгол хоршоо банк байгуулагдав.
- 1990.11.19** Худалдаа хөгжлийн банк, Хөрөнгө оруулалт, технологи, шинэчлэлтийн банк байгуулагдав.

1990.12.03 Авто зам банк байгуулагдав.

1991.01.31 Хөдөө аж ахуйн нэгдэл банк байгуулагдав.

1991 он: Улсын бага хурлын чуулганаар МУ-ын банкны тухай хуулийг баталж, Монгол Улсад төв банк, арилжааны банк гэсэн 2 шатлалт банкны систем үүсэв.

БАНКНЫ САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

- 1991:** Банкны тухай хууль батлагдаж, Монгол Улс Төв банк, арилжааны банк гэсэн хоёр шатлалт банкны тогтолцоонд шилжиж, Төв банкиг “Монголбанк” гэж нэрлэв.
- 1994:** “Эрдэнэсийн сангийн тухай хууль”-ийг батлуулав. Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааг тодорхойлж, түүх соёлын хосгүй үнэт зүйлийг хамгаалах, хадгалах эрх зүйн орчин бүрдэж Монголбанк үнэт металл худалдан авдаг болов.

1994: “Валютын зохицуулалтын тухай хууль”-ийг батлуулав.

1995: “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”-ийг батлуулж, банкны харилцагчдын эрхийг хамгаалав.

1996: Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хуулийг батлуулав.



- 1923.7.12** БХК(б)Н-ын Төв хорооны Улс төрийн товчооны 16-р хуралдаанаас Орос-Монголын банк яаралтай байгуулах тогтоолыг гаргаж, ОУ-ын Төв хорооны нарийн бичгийн дарга В.И.Сталин гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
- 1924.03.17** Засгийн газрын хуралдаанаас Монголын Худалдаа аж үйлдвэрийн банкны дүрмийг баталжээ.
- 1924.04.07-08-нд** Нийслэл хүрээнд МХАҮБ-ны хувь нийлүүлэгчдийн хурал болж, 6 сарын 2-нд нээхээр болов.
- 1924.06.02** нд МХАҮБ-ны 1-р хэлтсийг нийслэлд, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд үйлчилгээний хэлтэс

байгуулав.

- 1944 он:** МХҮБ Улаанбаатарт 1 хэлтэс, орон нутагт 21 хэлтэс, хадгаламжийн 17 кастай болсон байв.
- 1925.02.25** Засгийн газраас Банкны тэмдэгт гүйлгээнд гаргах онц эрхийг МХАҮБ-нд олгожээ.
- 1925.12.09** 1,2,5,10,25,50,100 төгрөгийн дэвсгэртийг гаргаж, гүйлгээнд оруулсан байна.
- 1925 он:** Улсын мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэхийг шалгах, дүрмийг Засгийн газраас гаргав.
- 1954 он:** ЗХУ МХАҮ банкинд оруулсан хувь хөрөнгөө МУЗГ-т шилжүүлэн өгөхөөр шийдвэрлэв.

ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ, ТОГТВОРЖУУЛАХ ХӨТӨЛБӨРҮҮД ХЭРЭГЖСЭН НЬ

- 1991:** ОУВС-ийн гишүүн орноор элсч мөн онд тус сангийн Стайнд бай хэлэлцээр хөтөлбөрт хамрагдав.
- 1993:** Эрчимжүүлсэн бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр -1
- 1997:** Эрчимжүүлсэн бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр -2 хамрагдаж, эдийн засаг, санхүүгийн хөтөлбөрүүдийг сайжруулах, бүтцийн өөрчлөлт хийх бодлогыг хэрэгжүүлж эхлэв.
- 2001:** Монгол Улс Олон Улсын Валютын Сангийн “Ядуурлыг бууруулж, өсөлтийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдаж, иргэдийн орлогыг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг хурдасгах бодлогыг хэрэгжүүлж эхлэв.
- 2009:** Стэнд бай хөтөлбөр хэрэгжүүлж эхлэв.
- 2017:** Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг 3 жилийн хугацаатай хэрэгжүүлж эхлэв.
- 1996:** ОУВС-ийн Article 8 -ийг мөрдөхөөр болж, хязгаарлалтгүй олон улсын төлбөр, гүйлгээ хийгдэх болов.
- 1996:** Олон улсын төлбөр тооцооны SWIFT сүлжээнд холбогдон, гадаад төлбөр тооцоог шуурхай дамжуулах боломжтой болж, гадаад орнуудтай хийх төлбөр тооцооны найдвартай байдлыг хангав.
- 2002:** “Иргэний хууль” хууль батлагдав.
- 2006:** Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль батлагдав. ФАТФ-ын олон улсын стандартын дагуу мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх тогтолцоотой болов.
- 2013:** Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль батлагдаж, хадгаламж эзэмшигчдийн 20 сая төгрөг хүртлэх хадгаламж даатгагдав.
- 2017:** “Үндэсний Төлбөрийн системийн тухай хууль”-ийг батлуулж төлбөр тооцоог бодит горимоор илүү найдвартай, түргэн шилжүүлдэг болов.

Дурдатгал




МОНГОЛ УЛСЫН АНХНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

Тусгаар тогтносон Монгол Улсын анхны мөнгөн тэмдэгт 1925 оны 12 дугаар сарын 9-нд төгрөг хэмээн нэрлэгдэж, гүйлгээнд гарчээ. Уг мөнгөнд 1924 оны анхны үндсэн хуулиар батлагдсан "соёмбо" сүлдийг үндсэн хээ болгон томоор тусгаж, уйгаржин монгол үсгээр бичиж хэвлэсэн байна.



С.ДОВЧИН

С.Довчин үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг анх гүйлгээнд гаргасан 1925 оны 12 дугаар сараас гадаадын бусад валютыг гүйлгээнээс түрэн гаргаж, Монголын зах зээл дээр төгрөг хууль ёсны ганц валют болон бэхэжсэн 1928 оныг хүртэл "Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах" ЗГ-ын комиссын гишүүнээр томилогдон ажилласан байна. Мөнгөний шинэтгэл хийх комиссын гишүүний хувьд 1926-1939 онд Монголбанкны орлогч дарга, жинхэнэ даргын албыг хашиж байсны хувьд ч монгол оронд шинэ тутам байгуулагдсан үндэсний банкиг бэхжүүлэх, банкны үйл ажиллагаанд мөрдөгдөх журмыг нарийн нягт боловсруулан, хэрэгжилтийг зохион байгуулахад С.Довчингийн зүтгэл, чармайлт их байжээ. С.Довчингийн Монголбанкны даргаар ажилласан зурвас үеийн ажлыг хүрээг харуулах 1940 оныг 1934 онтой харьцуулсан баримтаас дурдвал Монголбанкны тэнцлийн гүйлгээ 2.4, улсын бэлэн мөнгөний гүйлгээ 3.5, олгосон зээл 1.3 дахин өссөн байна. Мөн тэрбээр шинэ тутам байгуулагдсан монголбанкийг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлж, тэднийг улс орны эдийн засаг, аж ахуйн хөгжлийн төлөө хүчээ дайчлан ажиллаж сургахын төлөө их зүйлийг хийсэн гэдэг. Монголбанкны анхны монгол дарга болоод удаагүй байсан 1934 онд бичихдээ "Сүүлийн нэгэн жилд Монголбанк нь өөрийн аппаратыг монголчлох явдал дээр үлэмжхэн тооны монгол харьяат нарыг банкны ажил хэрэгт сургаж, банкны гүн гүнзгий гүйлгээний утга, чанарыг танилцуулан чадсан байна. Өнгөрсөн 10 жилийн дотор явуулсан Монголбанкны ажлыг үнэлэн үзвэл тус Монголбанк нь өөрийн улсын Засгийн газраас даалгасан зорилгыг үнэн зүрхнээс амжилттайгаар гүйцэтгэж чадсан юм" гэжээ.



Ю.ЦЭДЭНБАЛ

Ю.Цэдэнбал Монголбанкны дарга байхдаа МАХН-ын Х их хурлаас “БНМАУ-ын санхүү, мөнгө-зээлийн системийн гүйцэтгэх үүргийг нарийвчлан тодорхойлж, улс ардын аж ахуйн салбарт санхүүгийн сахилга батыг бэхжүүлэх, улс, олон нийтийн өмч хөрөнгийг үрэгдүүлэх шамшигдуулахаас хамгаалж, хяналтын хатуу зарчим тогтоох нь чухал” гэсэн заалт гаргуулжээ. Их хурлын дээрх заалтыг биелүүлэх зорилгоор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс “Үндсэн барилга, үндсэн зарлагыг Монгол банкнаар дамжуулан санхүүжүүлэх ба барилгын төсөв, төлөвлөгөөний хэргийг зохион байгуулж, барилгын хэргийг маш журамтай болгох тухай”, “Улсын дотор мөнгөний гүйлгээг журамтай болгох тухай”, “Аж ахуйн газруудын хоорондын тооцоог эмх журамтай болгох ба дебитор кредиторын өрийг устгах тухай” зэрэг олон тогтоол гаргаж байсан байна. Мөн “Үйлдвэр аж ахуйн газруудын эргэлтийн хөрөнгийн нормативыг тогтоох тухай” шийдвэр Сайд нарын Зөвлөл гаргасан нь эргэлтийн хөрөнгийг өөрийн ба зээлийн гэж нарийн зааглан, түүнд тавих хяналтыг сайжруулжээ. Ингэснээр Монголбанкны зээл, тооцоо, мөнгөн гүйлгээ, санхүүжилтийн ажлын арга хэлбэр улам боловсронгуй болсон байна. Үүнтэй уялдан Монголбанк зохион байгуулалтын хувьд өргөжин бэхжиж, бүх аймаг, зарим томоохон төв суурин газар өөрийн салбартай болж, Монголбанк удирдлага, зохион байгуулалтын талаар улам бэхжиж, тус улсын зээл, тооцоо, кассын төв болоод зогсоогүй төлбөр, тооцооны сахилга батад төрийн хяналт тавих үүрэг бүхий эдийн засгийн төв байгууллага болон өргөжжээ.



1939 ОНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

Энэ оны мөнгөн тэмдэгтийн нүүрэн талд “Соёмбо” болон “Д.Сүхбаатар”-ын хөрөг зургийг адил хэмжээ, харьцаатайгаар байрлуулж, ар талыг угалзаар чимэглэж, бичээс оруулсан.



1955 ОНЫ МӨНГӨН ТЭМДЭГТ

Энэ оны мөнгөн тэмдэгтийг зураач Шибү, Д.Амгалан нарын зургаар 1940 онд батлагдсан сүлд болон Д.Сүхбаатарын хөрөгтэй гаргасан байна. Улсын албан ёсны бичиг өөрчлөгдсөнтэй холбогдон мөнгөн тэмдэгт дээрх бүх үг, үсгийг кирилл үсгээр бичжээ. Тэр үеийн жишгээр дэвсгэртүүдийн хэмжээг нэлээд томруулсан.



Т.БАЛДАН

Т.Балдан нь 1940 оны 10 дугаар сарын 1-нээс Монголбанкны ерөнхий хорооны даргаар, 1954 оноос Улсын банкны ерөнхий хорооны даргаар тус тус томилогдож, 1955 оны гуравдугаар сар хүртэл 15 жил Монгол Улсын банкны Ерөнхий хорооны даргын хариуцлагатай албанд зүтгэжээ. Түүнийг Монголбанкны Ерөнхий хорооны даргаар ажиллаж байх үед буюу 1949 оны есдүгээр сарын 20-ны өдөр “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн анхны хурал болж, ЗГ-ын даалгавраар хоёр улсын зам харилцааны яамны зохион байгуулалт, дүрмийг баталсан юм. Ингэснээр “Улаанбаатар төмөр замын ерөнхий хороо байгуулагдсан билээ. Ерөнхий хорооны бүрэлдэхүүнд Зөвлөлтийн талаас Монголбанкны орлогч дарга И.А.Попов, ЗГ-ын санхүүгийн зөвлөх Александров, Үйлдвэрийн яамны зөвлөх Данилов, Монголын талаас Тээврийн яамны сайд С.Ядамсүрэн, Сангийн яамны сайд Д.Моломжац, Монголбанкны Ерөнхий хорооны дарга Т.Балдан нар орсон байна. Т.Балдан ийнхүү 1949 оны есдүгээр сараас 1953 оны гуравдугаар сар хүртэл Улаанбаатар төмөр замын Ерөнхий хорооны Монголын талын төлөөлөгчийн үүргийг хавсран гүйцэтгэж, Монголын төмөр замыг бүтээн босголцсон хүмүүсийн нэг юм.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

АРГАЛИЙН ТОЛГОЙТОЙ
ХОС АЛТАН СҮЛБЭЭР

ХОСГҮЙ ҮНЭТ

Урт: 13-14 см

Өргөн: 2.5-3.3 см

Жин: 76.84 гр

Эртний нүүдэлчдийн ур ухаан шингэсэн гайхамшигт хийцтэй өвөрмөц нэгэн дурсгалыг археологич Д.Наваан, Ц.Доржсүрэн, В.В.Волков нар 1971 онд илрүүлжээ. Монгол-Зөвлөлтийн түүх соёлыг судлах шинжилгээний анги Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш ууланд хүрэл зэвсгийн үеийн нэгэн /9-р/ булшийг малтсан байна. Уг булш 10 х 6 м хэмжээтэй, дөрвөлжин хэлбэрийн чулуун далантай байсан бөгөөд 1.8 м гүнд оршуулсан хүний хоёр санчигны тус газар уг алтан сүлбээрийг зөрүүлэн тавьсан байжээ. Тэдгээр сүлбээр нь ур хийцийн хувьд адил юм. Аргалийн толгойг загварчилсан байдлаар ур хийц сайтай үйлдэж, дорогш эргэсэн бахим эвэр, монхор сартгар хамар, хөнхөр том нүдтэй дүрсэлжээ.





МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсад банкны салбар үүсэж, хөгжсөний түүхт 95 жилийн ойн мэндийг нийт банкирууддаа хүргэж байгаадаа баяртай байна.

Монголын Банкны Холбоо нь 2000 онд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа банкны болон бусад санхүүгийн байгууллагуудын сайн дурын үндсэн дээр байгуулагдсан, гишүүддээ үйлчилдэг, хараат бус, бие даасан, ашгийн бус төрийн бус байгууллага юм.

Манай Холбоо нь өдгөө арилжааны 13 банк, Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Зээлийн батлан даалтын сан, Сумитомо Мицубиш банкны Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Токио Мицубиши банкны Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Банк оф Чайна Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, ЮнионПэй Интернейшнл, Монголын ипотекийн корпораци, Зээлийн мэдээллийн төв ХХК, Банк санхүүгийн академи зэрэг компаниудыг эгнээндээ нэгтгэсэн, гишүүддээ хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн Холбоо болон өргөжөөд байна.


Манай байгууллага нь банк, санхүүгийн мэргэжилтнүүдийн нэгдэл, мэргэжлийн холбоо болохын хувьд Холбооны ажлын албаны дэргэд мэргэжлийн зөвлөлүүдийг байгуулан ажиллуулж байна. Мэргэжлийн зөвлөл байгуулагдсанаар гишүүн байгууллагуудын мэргэжилтнүүд чиглэл чиглэлээр уулзаж, мэдлэг, туршлагаа хуваалцах, хамтдаа хөгжих, цаашлаад тулгамдаж буй асуудлуудаа тодорхойлох, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх зэргээр хамтран ажиллах боломж бүрдэж байгаа юм. Энэ чиглэлийн үйл ажиллагаа, банкирууд хоорондын харилцан хамтын ажиллагаа маань өдрөөс өдөрт өргөжин тэлж, үр дүнгээ өгч байна.

Ингээд банк санхүүгийн салбарт ажиллаж байсан, байгаа үе үеийн нийт мэргэжилтэн, банкирууддаа банкны салбар үүсэж, хөгжсөний түүхт 95 жилийн ойн мэндийг Холбооны Удирдах Зөвлөлийн гишүүд болон ажлын албаны нэрийн өмнөөс хүргээд, цаашдын ажил үйлсэд нь улам их амжилтыг хүсье.

МОНГОЛЫН БАНКНЫ ХОЛБООНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.ҮНЭНБАТ

БАНКНЫ САЛБАРЫН ЗУУЧЛАЛ, ХҮРТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Жил ирэх тусам банкны салбарын зуучлал нэмэгдсээр байна. Манай дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулахад банкны нийт актив 93 хувь, нийт зээл 53 хувь, иргэдийн зээл 31 хувь, жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)-ийн зээл 10 хувьтай тус тус тэнцэж байгаа нь эдийн засаг дахь санхүүгийн зуучлалын үүргийг банкны салбар дангаараа үүрч явааг дээрх тоо бэлхнээ илэрхийлж байна.



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Өрх гэр, аж ахуй нэгжийн амьдралтай эдийн засгийн хувьд шууд холбогддог салбар бол банк, санхүүгийн салбар. Ялангуяа хүний мөнгө, эд хөрөнгө, хувийн мэдээлэлтэй холбоотой байдаг нь банкнаас итгэлтэй, найдвартай, хариуцлагатай байхыг шаарддаг. Тэгэхээр Монголын 3.2 сая иргэн, 167 мянган аж ахуй нэгж байгууллагын төлбөр тооцоо, зээл, хадгаламж гэх мэт санхүүгийн түргэн шуурхай, баталгаатай үйлчилгээг үзүүлэх үүрэг хүлээсэн банкны салбарын 15 мянган гаруй ажилтан байдаг. Энгийн тооцоолол хийвэл банкны 1 ажилтан бүрт 224 иргэд болон аж ахуй нэгж ногдож байгаа юм.

2018 оны байдлаар Монгол улсын 1 иргэн 2 харилцах данстай, 1.1 хадгаламжийн данстай байгаа бол 3 хүн тутмын 1 нь зээлийн данстай байна. Энэ нь Монгол улсын иргэн бүрт санхүүгийн үйлчилгээ хүртээмжтэй болохыг илтгэж байгаа юм. Түүнчлэн харилцагчид жилд 146 сая удаа ПОС машинаар, 93 сая удаа АТМ-ээр, 54 сая удаа мобайлаар тус тус гүйлгээ хийжээ. Энэ тоо жил ирэх тусам өсч байгаа юм. Техник, технологи хөгжиж буйтай холбоотойгоор хүмүүсийн банкинд очиж үйлчлүүлэх нь багасч интернет болон мобайл банкаар гүйлгээ хийдэг харилцагч нарын тоо нэмэгдэж байна. Тухайлбал улсын хэмжээнд хоёр хүн тутмын нэг нь мобайл банктай байгаа бол гурван хүн тутмын хоёр нь интернет банк эзэмшиж байна.

Том дүр зургаар харвал Монголын эдийн засгийн өсөлт 2018 онд 6.9 хувьтай, 2019 оны эхний улиралд 8.6 хувьтай гарсан байна. Ерөнхийдөө эдийн засгийн өсөлтийн тал нь түүхий эдийн үнэ, экспорт, гадаадын шууд хөрөнгө оруулалт зэрэг гадаад хүчин зүйлсээс хамаарч бий болдог. Харин үлдсэн тал хувийн өсөлтийг дотоод эдийн засгаас буюу мөнгөний зөөлөн бодлоготой холбоотой зээлийн хүү буурч, улмаар банк санхүүгийн салбарын зээлээр дамжин бусад салбаруудыг дэмжиснээр бий болов. Улмаар үйлчилгээ, худалдаа, барилга, уул уурхай гэх мэт салбарууд өсөх нь нэг талаар ажлын байрыг нэмэгдүүлдэг бол нөгөө талаараа цалин өсөх боломж бий болгодог. Энэ нь өрхийн орлогыг нэмэгдүүлж, өрхүүд нь эргээд хэрэглэх болон хадгалах байдлаар эдийн засгаа дэмждэг.



БАНКНЫ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦОО

Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк (Монголбанк) анх үүсгэн байгуулагдахад түүний дэргэд Шалган байцаах комисс байгуулагджээ. Улмаар 1929 онд Хянан зааварлах хэлтэс тус банкны Ерөнхий хорооны бүтцэд шинээр бий болсноор банкны хяналт шалгалтын тогтолцооны үндэс тавигдсан түүхтэй.

1990 онд улс төр, нийгэм, эдийн засагт шинэчлэл хийгдэж, 1991 оны 5 дугаар сард Банкны тухай хууль батлагдсанаар Монголбанкийг Улсын банкны суурин дээр байгуулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 1991 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 3/5 дугаар тушаалаар Хяналт шалгалтын газрыг байгуулсан нь 2 шатлалт банкны системийн хяналт шалгалтын тогтолцоо үүсэж, хөгжих нөхцөл болов.

Хяналт шалгалтын газар үүсгэн байгуулагдсанаар банкны системийн хоёр шатлалт тогтолцоог бүрдүүлэх, арилжааны банкуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, Монголбанкнаас банкуудын үйл ажиллагаанд мөрдүүлэх журам, заавруудыг шинээр боловсруулах, банкны хяналт шалгалтын талаар олон улсын туршлагыг судалж нэврүүлэх, Төв банкны тухай болон Банкны тухай хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудад хяналт шалгалтын чиглэлээр санал өгөх, банкуудын үйл ажиллагаанд шалгалт хийж, заавар зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг эхлүүлсэн юм.

Банкуудын актив өсөхийн хэрээр Монголбанкны хяналт шалгалтын хамрах хүрээ, үүрэг улам өргөжжээ. Тиймээс банкны системийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкуудын дүрмийн сангийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх, олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран санхүүгийн системд бүтцийн өөрчлөлт хийх зэрэг хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах алхмуудыг хийсэн билээ. Арилжааны банкны санхүү, төлбөрийн чадварыг үнэлж дүгнэх замаар тэдгээрийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих үүднээс олон улсын болон Базелийн хорооны жишгээр “Арилжааны банкны үйл ажиллагааг дүгнэх журам”-ыг шинээр боловсруулж, 1995 оны 7 дугаар сараас эхлэн мөрдүүлэн ажиллаж эхэлсэн юм.

Мөн төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдсон буюу төлбөрийн чадвар нь суларч болзошгүй болсон банкинд хуульд заасны дагуу онцгой дэглэм тогтоох, эрх хүлээн авагч томилон татан буулгах зэрэг албадлагын арга хэмжээ авах асуудлыг боловсронгуй болгох чиглэлээр олон улсын банк санхүүгийн байгууллагуудын зөвлөмж туслалцааг авч 1996 оны Банкны тухай шинэ хуульд тусгав. Улмаар 1996-2000 он буюу банкны хямралын үед тус хуулийн дагуу Ард, Даатгал банкинд Банкны эрх хүлээн авагчийг томилж, банкны хувь нийлүүлэгчдийн оруулсан



хөрөнгийн хэмжээгээр хариуцлага хүлээлгэн, банк өмчлөх эрхийг цуцалжээ. ХОТШ, Сэргээн босголт, ХАА-н банкуудад онцгой дэглэм тогтоосноор тэдгээрийн хэвийн үйл ажиллагаа хангагдаагүй тул банкны эрх хүлээн авагч томилж, ХОТШ, Сэргээн босголт банкныг татан буулгахаар шийдвэрлэж байжээ.

2010 онд Банкны тухай хуулийг дахин шинэчлэн найруулжээ. Ингэхдээ аливаа этгээдийн холбогдох этгээдийг илүү өргөн хүрээтэй тодорхойлж өгснөөс гадна банкны системд тулгараад байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг өгөхүйц, ирээдүйд банкны салбарын тогтвортой байдлыг хангах хэд хэдэн зохицуулалтыг тусгасан байна. Тухайлбал, албадлагын арга хэмжээ авах зарчмыг нарийвчилж өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлттэй холбож өгсөн юм. Мөн банкны хөрөнгө оруулагчдад тавих шаардлагыг өндөрсгөж ёс зүйтэй, зөвхөн хууль ёсны үйл ажиллагаанаас олсон хөрөнгөтэй хөрөнгө оруулагч нар банкны хувь нийлүүлэгч байхаар зохицуулагдав. Түүнчлэн банкны холбогдох этгээдүүд болох нэг нэгдлийн доор үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдүүдээс банкинд үзүүлж байгаа нөлөө, учруулж болзошгүй эрсдэлд нэгдсэн хяналт тавьж байх зэрэг банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий зохицуулалтууд тусгагдав.

Банкны тухай хууль шинэчлэн батлагдсан, олон улсын шилдэг шинэ туршлага, хандлагыг

нэвтрүүлэх, санхүүгийн хямралын үед гарч байгаа доголдол, дутагдлыг арилгах зорилгын хүрээнд Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны журам болон Актив ангиллын журмыг 2010 онд шинэчлэн баталжээ.

МУ-ын Засгийн газрын шийдвэрийн дагуу 2017 оны 5 дугаар сараас эхлэн манай улсад хэрэгжиж эхэлсэн ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанк ОУВС-ийн техник туслалцаа, дэмжлэгтэйгээр банкны системд томоохон эерэг өөрчлөлтүүд хийсэн нь банкны салбарын эрх зүйн зохицуулалт, Монголбанкнаас банкинд хяналт тавих үйл ажиллагааны хууль эрх зүйн орчинг олон улсын зарчим, хэм хэмжээнд тулгуурлан боловсронгуй болгоход зорив. Төв банк, Банкны тухай хууль, холбогдох хуулиудын нэмэлт, өөрчлөлтийг 2018 онд батлуулснаар банкны системийн найдвартай байдлыг илүү бэхжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зарчмыг хэрэгжүүлэх болсон юм.

Мөн тус хөтөлбөрийн хүрээнд олон улсын стандартад нийцсэн аргачлалаар банкуудын активын чанар, эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлсэн нь Азид анх удаа олон улсын стандартаар активын чанарын үнэлгээг хийлгэв. Тус үнэлгээгээр уул уурхайн лицензийн үнэлгээний аргачлалыг тодорхойлсон нь бусад улс орнуудад хийгддэг активын чанарын үнэлгээнээс онцгой ач

холбогдолтой байв. Чанаргүй зээл нь банкны актив хөрөнгийг бууруулах, банкны ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийг хорогдуулж, зээлийн хүүгийн түвшинг өндөр байлгах сөрөг үр дагавартай төдийгүй банкны тогтолцооны төлбөрийн чадварт шууд нөлөөлдөг тул чанаргүй зээлийг бууруулах стратеги, төлөвлөгөөг 2018 оны 6 дугаар сард батлуулсан юм.

Монголбанкны Хяналт шалгалтын газар нь сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд банкны хоёр шатлалт тогтолцоо болон хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, боловсронгуй болгохоор олон улсын сайн туршлага, стандарт, зөвлөмжийг банкны системд нэвтрүүлэх, шинэ заавар журмуудыг боловсруулан гаргах, банкны салбарт үүссэн тухайн үеийн хямралуудыг даван туулах, харилцагч хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зэрэг үйл ажиллагаанд голлох үүрэгтэйгээр оролцож ирсэн юм. Монгол Улсын банкны хяналт шалгалтын тогтолцоог улам боловсронгуй болгохын тулд олон улсын жишгийг баримталж Базелийн цуврал стандартыг шат дараатай нэвтрүүлж эхлээд байна. Энэ нь санхүүгийн тогтвортой байдал, харилцагчдын эрх ашгийн төлөө зорьж буйд юм.



"АЛТ" ХӨТӨЛБӨР, МОНГОЛБАНКНЫ АЛТ ХУДАЛДАН АВАЛТ

Зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц бэрхшээл хүндрэлээр дүүрэн, юуны түрүүнд мөнгө хэрэгтэй байв. Энэ үед алтны нөөц ашиглаж, улсын санхүүг нэмэгдүүлэх асуудал сөхөгдсөнөөр 1991 онд Засгийн газар "Алт хөтөлбөр"-ийг батлав.

Алт хөтөлбөрийг хэрэгжүүлснээр алтны жижиг дунд шороон ордуудыг нээн олборлож, алтны салбарыг эрчимтэй хөгжүүлэх замаар гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд зорьж байв.

Банк санхүүгийн салбарын ахмад ажилтан Б.Шүхэрт "...анх тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 10-15 тэрбум төгрөг шаардлагатай байсан юм. Гэвч тэр үед ийм хэмжээний мөнгө олоход бэрх байв. Түлш, эрчим хүчний яамны Эрдэс баялгийн санд 300-400 сая төгрөгийн нөөц байж. Энэ бол асар их мөнгө байв. Гэсэн ч цаана нь дутагдаж байгаа мөнгийг олох шаардлагатай тул мөнгөтэй гэсэн байгууллага бүрт толгой дараалан хандаж байсан юм. Ингэснээр 1993 онд 1 тэрбум төгрөгийн мөнгөн хуримтлалтай

болсон байна. Энэ мөнгөөр "Алт хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх суурь тавигдсан" гэж дурссан байдаг.

Хөтөлбөр хэрэгжихээс жилийн өмнө Монголбанкинд зургаан аж ахуйн нэгж 0.8 тонн алт тушааж байсан бол үе шаттай хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнд 2005 гэхэд 133 аж ахуйн нэгж 15.2 тонн алт тушаасан нь 1991 оныхтой харьцуулахад 19 дахин өссөн үзүүлэлт ажээ. Харин 2006 онд Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг мөрдөж эхэлснээр алт олборлогчдоос Монголбанкинд тушаах алтны хэмжээ эрс буурч 2010 онд 2.1 тонн болсон байна.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан УИХ-аас 2011 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн уг хуулийг хүчингүй болгож, "Ашигт малтмалын тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Үүний үр дүнд Монголбанкинд тушаах алтны хэмжээ 2015 онд 95 үйлдвэрээс 3.3 тонн, 2013 онд 72 үйлдвэрээс 6 тонн хүрч нэмэгдсэн байна. Цаашид тушаасан алтны хэмжээг

дахин нэмэгдүүлэхэд төр засгаас онцгой анхаарч Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 2.5 хувь, нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү байхаар зааж, 2014 оны нэгдүгээр сараас эхлэн дагаж мөрдсөн байна. Хууль мөрдөгдсөнөөр 2014 оны эхний дөрвөн сарын байдлаар 2 тонн алт худалдан авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 600 гаруй кг-аар өсжээ.

Мөн алтны худалдан авалтыг нэмэгдүүлэхийн тулд Монголбанкны Ерөнхийлөгч, Уул уурхайн болон Сангийн сайдын 2015 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн хамтарсан тушаалаар "Алт худалдан авах урьдчилгаа санхүүжилтийн арга хэмжээ"-г баталж, нийт 5.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Засгийн газрын өрийн баталгаатайгаар олгохоор шийдвэрлэсэн. Үүнээс гадна 2016 онд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар



Монголбанкны алт худалдан авах үнийн бодлогод өөрчлөлт оруулж, алт худалдан авах ханшийг дэлхийн зах зээлийн үнэтэй бүрэн нийцүүлсэн, алт худалдан авалтыг нэмэгдүүлэх зорилгоор гурван сарын хугацаанд "Алт" аяныг зарласны дүнд 2016 онд 18.3 тонн, 2017 онд 20.0 тонн, 2018 онд 22 тонн болж тус тус өсөв.

2017 онд Алт хөтөлбөрийн хоёр дахь үеийг эхлүүлэхээр шийдвэрлэж, Засгийн газрын 20 дугаар тогтоолоор "Алт-2" үндэсний хөтөлбөрийг баталжээ. Монгол Улсын алтны үйлдвэрлэлийн ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж алт олборлох, боловсруулах үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи, менежмент нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн үр дүнг сайжруулах, алтны үйлдвэрлэлээс эдийн засагт оруулах өгөөжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн чадавхыг өсгөхөд энэхүү үндэсний хөтөлбөрийн гол зорилго оршиж байв.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх замаар эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх, тогтвортой өсөлтийг хангах зорилтууд тусгагдсан нь "Алт-2" хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болов.

АЛТ-2 ХӨТӨЛБӨРИЙН ҮНДСЭН ЗОРИЛТ НЬ:

1. Татвар, хууль эрх зүйн таатай, тогтвортой орчинг бүрдүүлнэ;
2. Геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг алтны хэтийн төлөв бүхий бүсийн хэмжээнд нэмэгдүүлэх замаар Монгол Улсын ашигт малтмалын сан хөмрөгийг тогтвортой арвижуулан баяжуулна;
3. Алтны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, техник, технологийг сайжруулж шинэчилснээр олборлох

ТӨРЦ АЛТ

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар бүлэг, 8 дугаар зүйлд заасны дагуу Монголбанк нь Монголбанкнаас зарласан алт худалдан авах үнээс 10 хувиар өндөр үнээр төрц алтыг худалдан авч Эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг баяжуулдаг.



- алтны хэмжээ, металл авалтын хувь, хэмжээг өсгөх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлнэ;
4. Алтны үйлдвэрлэлийн явцад байгальорчныг хамгаалах болон үйлдвэрлэл явагдаж дууссаны дараа нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт, хариуцлагын иж бүрэн тогтолцоог бий болгоно;
 5. Бичил уурхайгаар алт олборлох, борлуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох зэрэгт оршино гэж тодорхойлсон байна.

Монголбанкнаас "Алтны зах зээлийн төлөв, дунд хугацааны чиг хандлага", "Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах боломжийн тухай" судалгааны ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнээс гадна Дархан-Уул, Баянхонгор аймагт сорьцын лаборатори байгуулан, алтыг худалдан авах үйл ажиллагааг Монголбанкны салбар болон арилжааны банкаар гүйцэтгүүлж байна.

МОНГОЛБАНКНЫ АЛТ ХУДАЛДАН АВАЛТ

Монголбанкинд 1999 онд 99 үйлдвэрээс 10,902.4 кг, 2001 онд 117 үйлдвэрээс 13,760.03 кг, 2005 онд 133 үйлдвэрээс 15,232.9 кг алт худалдан авсан байна. Хэдийгээр жил болгон алт худалдан авалт нэмэгдэж байсан ч 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн "Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хууль" үйлчилж эхэлснээр 2006 онд 130 үйлдвэрээс 9,024.4 кг, 2010 онд 106 үйлдвэрээс 2,116.6 кг алт худалдан авсан нь алт олборлогчид алтаа тушаах нь эрс багассантай холбоотой юм.

Үүнтэй уялдуулан 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн "Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хууль"-ийг хүчингүй болгон "Ашигт малтмалын тухай" хуульд өөрчлөлт оруулан Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 5 хувь, нэмэлт төлбөрийн хэмжээ зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч 0-ээс 5 хүртэл хувьтай тэнцүү байхаар болгов.



МОНГОЛБАНКНЫ АЛТ ХУДАЛДАН АВЧ БАЙГАА ЗОРИЛГО

1. Гадаад валютын улсын нөөцийг бүрдүүлэх голлох эх үүсвэрийн нэг нь Монгол Улсын алтны олборлолт буюу олборлосон алтаа Монголбанкинд худалдах байдал юм.
2. Гадаад валютын улсын нөөцийн удирдлагыг хууль, эрх зүйн хүрээнд Монголбанк хэрэгжүүлдэг.
3. Хариуцлагатай уул уурхайг дэмжих.

МОНГОЛБАНКИНД АЛТАА ХУДАЛДСАНААР ҮҮСЭХ ДАВУУ ТАЛ

1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) 5% төлнө. (Олборлогч өөрөө экспортлоход АМНАТ 10%, экспортын зардал нэмэгдэнэ),
2. Монгол Улсын олборлон баяжуулж байгаа алтны дундаж агуулга 85.0 хувь байдаг тул алтыг олон улсын зах зээлд борлуулахад 99.99 хувийн цэвэр алт болгох шаардлагатай. Гадаадад алтыг цэвэршүүлэхэд алтны экспортын татвар, тээвэр, даатгал, хамгаалалтын зардал гардаг. Харин та Монголбанкинд алтаа худалдсанаар Лондонгийн үнэт металлын захын үнээс 2 ам.долларыг хасаж эрсдэлгүй, бусад нэмэлт зардалгүйгээр алтаа худалдах боломжтой.
3. Та Монголбанкинд алтаа худалдсанаар Монгол Улсын гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх, төгрөгийн тогтвортой байдлыг хангахад өөрийн хувь нэмрээ оруулна.
4. Таны алтанд агуулагдах цагаан мөнгөний үнийг Монголбанк тооцож төлнө.


Энэ арга хэмжээний үр дүнд 2012 онд 95 үйлдвэрээс 3,344.5 кг, 2013 онд 72 үйлдвэрээс 6,041.9 кг алт худалдан авсан нь өмнөх үеээс нэмэгдсэн боловч санасан хэмжээнд хүрэхгүй байсан тул төр засгаас онцгой анхаарч "Ашигт малтмалын тухай" хуульд нэмэлт өөрчлөлт оруулан "Монголбанк түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 2.5 хувь, нэмэлт төлбөрийн хэмжээг 0 хувьтай тэнцүү" байхаар зааж 2014 оны 01 дүгээс сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөнөөр 2014 оноос эхлэн алт худалдан авалт эрс өссөн үзүүлэлттэй байна. 1990-2018 онд

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээг дараах дүрслэл 1-т харуулав.

Тус дүрслэлээс харахад Монголбанкинд алт тушаалт нь алтны дэлхийн зах зээлийн үнээс биш зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээнээс шууд хамаарч байна.

Улсын Их Хурлын 2019 оны 3 дугаар сарын 26-ны ээлжит бус чуулганаар "Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийг баталж АМНАТ=5%+0% болсон ба энэхүү өөрчлөлт нь 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөс хүчин төгөлдөр болов.


Дүрслэл 1. 1990-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ



Эх сурвалж: Монголбанк



Дүрслэл 2. Байгууллага, иргэдийн тушаасан алтны хэмжээ (кг)



Эх сурвалж: Монголбанк

МОНГОЛБАНКНААС АЛТ ХУДАЛДАН АВАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Монголбанк алт худалдан авалтыг нэмэгдүүлэх, албан бус сүлжээг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:

1. 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс Монголбанкинд худалдан авах алтны үнийг Лондонгийн үнэт металлын зах дээрх хамгийн сүүлийн алтны үнээс 2 ам.долларыг, цагаан мөнгөний үнийг Лондонгийн үнэт металлын зах дээрх хамгийн сүүлийн цагаан мөнгөний үнээс 1 ам.долларыг хасч тооцдог болов.
2. 2016 онд 11 дүгээр сарын 11-ний өдрөөс Монголбанк алт худалдан авах цагт өөрчлөлт оруулан Монголбанкны алт худалдан авах цагт амжиж алтаа худалдаагүй бол тухайн өдрийн алтны үнээр хадгалуулж, дараагийн өдөр төлбөр тооцоог шилжүүлдэг болов.
3. "Алт 2" Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2017 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс 3 сарын хугацаанд "Монгол алт" аян, 2018 оны 6 дугаар сарын 4-ний өдрөөс 5 сарын хугацаанд "Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа" аяныг дахин зохион байгуулж байна. Аяны зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагууд олборлосон алтаа Монголбанк болон арилжааны банкуудад худалдаж, алт худалдан авалтыг нэмэгдүүлэх, олон нийтийн дунд алт худалдан авах үйл ажиллагааны талаар сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, холбогдох хууль, журмыг таниулахад оршино. Мөн Монгол Улсын гаалиар зөвшөөрөлгүй алт гаргах үйлдлийг бууруулах, хариуцлагатай уул уурхайг дэмжих, тэдний үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, Монголбанкны худалдан авч буй алтны үнийн талаар болон бусад мэдээллийг олон нийт, байгууллагад хүргэх, таниулах юм.
4. 2017 оны 8 дугаар сарын 7-ны өдрөөс алт тушаагч байгууллага, иргэдийн үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх зорилгоор "Гэрчлэх бичиг" олгож эхэлсэн.
5. 2018 оны 10 дугаар сард Дархан-Уул, Баянхонгор аймагт сорьцын лаборатори байгуулан, алт худалдан авалтын нэг цэгийн үйл ажиллагааг эхлүүлэв.



Төгрөгийн гадаад валюттай харьцдах ХАНШ яаж тогтдог вэ?



Уул уурхай



Ноолуур



Түүхий нефть

Бусад

Орох урсгал Нийлүүлэлт

Гадаад валютын орох урсгал гарах урсгалаас давах үед валютын нийлүүлэлт нэмэгдэж валютын ханш буурна.



Гадаад
Валютын Ноон



Гарах урсгал Эрэлт

Гадаад валютын гарах урсгал орох урсгалаас давах үед валютын эрэлт нэмэгдэж валютын ханш өснө.



Гадаад валютын эрэлт, нийлүүлэлтээс хамаарч ханш тогтоно.



Бусад

Тоног
төхөөрөмжийн

импорт

Бензин



Барилгын
материал



Аялал
жуулчлал





ТӨГРӨГИЙН ХАНШ БА ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбоотойгоор олон улсын худалдаа идэвхжиж, гадаад валютын эрэлт, нийлүүлэлт нэмэгдсэнээр Монгол Улс тогтмол ханшийн дэглэм баримтлах боломжгүй болж, улмаар Монголбанкны Ерөнхийлөгчийн 1993 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 3/145 дугаар тушаалаар тогтмол ханшийн дэглэмийг халсан байдаг. Түүнчлэн 1996 онд банкны хоёр шатлалт системд шилжиж, Төв банк /Монголбанк/-ны тухай хууль батлагдан “Монгол Улсад валютын ханш чөлөөтэй бөгөөд бодитой тогтоно” гэж заасан нь хөвөгч ханшийн дэглэмд шилжих үндэс суурийг албан ёсоор тавьсан гэж хэлж болно.

Ийнхүү төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэн, уян хатан тогтох болсон бөгөөд Төв банк, арилжааны банк гэсэн хоёр шатлал бүхий банкны шинэ тогтолцооны үндэс тавигдсан 1996 оноос өнөөг хүртэлх ханшийн хөдөлгөөнийг чиглэл болон өөрчлөлтийн хурдаас нь хамааруулж 6 үед хуваан

тайлбарлах боломжтой юм. Үүнд манай орны гадаад валютын ханшийн хөдөлгөөнийг тайлбарлах чадвартай макро эдийн засгийн гол хувьсагчид нь мөнгөний нийлүүлэлт, төлбөрийн тэнцэл, түүхий эдийн үнэ, тэр дундаа зэсийн үнэ байв.

1. БАНКНЫ САЛБАРЫН ХҮНДРЭЛ: 1996-1999 ОН

Зүүн өмнөд Азийг хамарсан санхүүгийн хямрал, Орос улсын санхүү, эдийн засгийн хямрал зэрэг гадаад хүчин зүйлс манай улсын эдийн засагт шууд болон шууд бус замаар сөрөг нөлөө үзүүлж, зээл тусламжийн хэмжээ буурч, гадаад худалдааны нөхцөл муудав. Иймд эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх, улсын төсвийн орлогоос үүдэлтэй төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зэрэг шаардлагаар мөнгөний нийлүүлэлт 1996-1999 онд 2.2 дахин нэмэгдсэнээр төгрөгийн ам.доллартай харьцах ханш 597 төгрөг буюу 126.1%-иар суларсан байна.

Гэсэн хэдий ч 1996, 1998 оны банк санхүүгийн хямралын дараа банкуудын зээл олгох сонирхол

буурч, ТБҮЦ болон гадаадын банкууд дахь харилцах, хадгаламж зэрэг эрсдэл багатай активт эх үүсвэрээ байршуулах сонирхол илт давамгайлах болсон тул ТБҮЦ-ны хүү болон хэмжээгээр дамжуулан мөнгөний хатуу бодлогыг хэрэгжүүлсэн бөгөөд Монголбанкны интервенцийн хэмжээ өмнөх оноос цэвэр дүнгээр 2.6 дахин буурч 28.2 сая ам.долларт хүрсэн байна.

2. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ СЭРГЭВ: 2000-2006 ОН

Монгол Улсын эдийн засаг 2000-2006 онд жилд дунджаар 6.0 хувиар өссөн бөгөөд дэлхийн зах зээл дээрх цэвэршүүлсэн зэсийн үнэ өсч, Монгол улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэнээр төлбөрийн тэнцэл дээрх хугацаанд 543.7 сая ам.долларын ашигтай гарчээ.

Гадаад болон дотоод эдийн засгийн нөхцөл байдал таатай байсан энэ үед Төв банк болон Засгийн газар мөчлөг дагасан мөнгөний болон сангийн бодлого хэрэгжүүлж эхлэв. Тус хугацаанд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 94.5 төгрөг буюу 8.8%-



иар суларчээ. Энэ нь нэг талаас төлбөрийн тэнцэл ашигтай, дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ өссөн зэргээс шалтгаалсан бол нөгөө талаас төв банкнаас валютын захад идэвхтэй оролцдог байснаас шалтгаалж байв. Тодруулбал төв банкнаас зах зээлд үүссэн гадаад валютын эрэлтийг хангах зорилгоор 2000-2006 оны хооронд цэвэр дүнгээр нийт 438.7 сая ам.доллартай тэнцэх хэмжээний гадаад валют нийлүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, Монголбанкнаас жилд дунджаар гадаад валютын албан нөөцийн 26 хувьтай тэнцэх хэмжээний валютыг захад нийлүүлж байжээ.

3. ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ХЯМРАЛ: 2007-2009 ОН

Дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ 2008 онд огцом унасан, дотоодын өргөн хэрэглээний барааны үнэ өссөн, эдийн засгийн идэвхжил суларсан зэрэг шалтгааны улмаас 2009 онд эдийн засгийн өсөлт -1.3 хувьд хүрэв. 2000-2006 онд хэрэгжүүлсэн мөчлөг дагасан бодлогын нөлөөгөөр Монгол Улсад хямралын үед авч хэрэгжүүлэх бодлогын орон зай хязгаарлагдмал байв.

Макро эдийн засгийн ийм нөхцөл байдалд Монголбанк 2009 оны эхээр мөнгөний бодлогын хүүг 4.25 нэгж хувиар нэмэгдүүлэн 14 хувьд хүргэж, гадаад валютын дуудлага худалдааг 7 хоногт 2 удаа тогтмол зохион байгуулдаг болов. Монголбанк 2007-2009 оны хооронд нийт 1,159.1 сая ам.доллар захад нийлүүлснээс 2008 онд хамгийн өндөр буюу гадаад валютын албан нөөцийн 109 хувьтай тэнцэх хэмжээний¹ валютыг

захад нийлүүлжээ. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар ОУВС-тай хамтран Стэнд-бай хөтөлбөрийг 2009 оны 4 дүгээр сараас эхлэн 18 сарын хугацаатай хэрэгжүүлэх шийдвэрт хүрч, хууль эрх зүйн хувьд гадаад валютын зохиомол эрэлтийг хязгаарлах зорилгоор Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн төслийг боловсруулан 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр УИХ-аар батлуулсан байна.

Эдгээр үйл явдал нь валютын ханшийн хэт хөөрөгдлөөс зайлсхийх боломжийг олгож, төгрөгт итгэх итгэл сэргэж, төгрөгийн ханш тогтворжин, банкны системээс харилцах, хадгаламж дайжих явдлыг зогсоож, улмаар мөнгөний бодлогыг сулруулах орон зайг бүрдүүлж өгсөн ч 2007-2009 онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 282 төгрөг буюу 24.2%-иар суларчээ.

4. ВАЛЮТЫН ОРОХ УРСГАЛ НЭМЭГДЭВ: 2010-2012 ОН

Дэлхийн зах зээл дээрх цэвэршүүлсэн зэсийн үнэ 2009 оноос эхлэн өсч, 2011 оноос уул уурхайн томоохон ордуудыг ашиглаж эхэлснээр Монгол улсыг чиглэсэн санхүүгийн хөрөнгийн урсгал нэмэгдэж, эдийн засгийн өсөлт 17.3 хувьд хүрэв. Үүний зэрэгцээ Засгийн газар мөчлөг дагасан төсвийн бодлогыг хэрэгжүүлж иргэн бүрт бэлэн мөнгө олгож, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, орон сууц худалдаж авахад үзүүлэх хөнгөлөлт, оюутны сургалтын төлбөр, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан халамжийн бодлого явуулж, 2010 онд нийт 315 тэрбум, 2011 онд 804 тэрбум, 2012 онд 840 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Төсвийн үр ашиггүй тэлэх бодлого нь дотоодын хэрэглээг урамшуулж, улмаар бараа бүтээгдэхүүний импортын өсөлт, үйлчилгээний дансны алдагдлын өсөлтөөс шалтгаалсан урсгал дансны алдагдлыг нэмэгдүүлэв. Бараа бүтээгдэхүүний үнэ өсч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларч, Монгол Улсын гадаад валютын нөөц огцом буурав. Улмаар Монголбанк Хятадын Ардын банктай 5 тэрбум юаньтай тэнцэх үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээг 2011 оны 5 дугаар сард анх байгуулсан бөгөөд хэлцлийн хэмжээг 2012 онд 10 тэрбум юань, 2014 онд 15 тэрбум юань хүртэл тус тус нэмэгдүүлсэн байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар 2012 оны 12 дугаар сард анх удаа олон улсын зах зээлд 1.5 тэрбум ам.долларын үнэт цаас (Чингис бонд) гарган арилжаалжээ.

5. ТӨВ БАНКНЫ ТӨСВИЙН ШИНЖТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА: 2013-2016 ОН

Дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ 2013-2016 оны хооронд тонн тутамд 7913 ам.доллараас 5501 ам.долларт хүрч даруй 30.5 хувиар буурав. Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2016 оны эцэст -4,156.4 сая ам.долларт хүрч 2012 оны мөн үеэс 8,428.9 сая ам.доллараар буурсан байна. Түүнчлэн Монголбанк "Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөр" болон бусад Засгийн газрын төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд 2012-2016 онд нийт 7.3 их наяд төгрөгийн эх үүсвэрийг зах зээлийн хүүнээс бага хүүгээр эдийн засагт нийлүүлсэн нь төгрөгийн ханш огцом сулрах дарамт бий болов.

¹ 2008 онд хийсэн нийт интервенцийг тухайн оны эцсийн байдлаарх ГВАН-тэй харьцуулав.



Иймд төв банкнаас 2013-2016 оны хооронд цэвэр дүнгээр 5.2 тэрбум ам.долларын интервенц хийж валютын захад оролцсон байна. Улмаар гадаад валютын улсын цэвэр нөөц 2014 оны 10 дугаар сараас эхлэн сөрөг утгатай болж, 2012 оны эцэстэй харьцуулахад Засгийн газар, төв банкны гадаад өрийн хэмжээ 2.5 тэрбум ам.доллар буюу 60 хувиар нэмэгджээ. Валютын захад төгрөгийн ханш огцом суларна гэсэн хүлээлт давамгайлж, банкууд болон банк бус санхүүгийн байгууллагууд харилцагчдад худалдах гадаад валютын хэмжээнд хязгаар тогтоох, зарим үед зогсоох арга хэмжээ авч байв. Хятадын ардын банктai байгуулсан своп хэлцлээр бүрдүүлсэн гадаад валютын нөөц шавхагдаж, эцэстээ 2016 оны 2 дугаар хагасаас Монголбанкнаас валютын захад интервенц хийх боломж хумигдав. Ийнхүү 2016 оны 8 дугаар сард Монголбанк бодлогын хүүгээ өмнө нь байгаагүй өндөр дүнгээр буюу 4.5 нэгж хувиар нэмэгдүүлж 15 хувьд хүргэх бодлогын зайлшгүй шийдвэрийг гаргаж байв.

6. ӨРГӨТГӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨРТ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЛЭВ: 2017 ОНООС ХОЙШ

Эдийн засагт үүссэн хүндрэл болон 2016 оны сүүлийн хагаст хийгдэх том дүнтэй гадаад өрийн эргэн төлөлтийг Монгол Улс өөрийн дотоод нөөц боломжоор дангаар шийдвэрлэж чадахааргүй байсан тул олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, бусад улс орнуудын урт хугацаатай, хөнгөлттэй зээл, тусламжийг авах зайлшгүй шаардлага үүсэв. Тиймээс Монгол Улсын Засгийн газар


2017 оны 5 дугаар сараас эхлэн ОУВС-тай хамтран "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж эхлэв. Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр Хөгжлийн банкны евро бонд, Чингис бонд болон Дим сам бондын төлбөрийг Засгийн газрын бондоор амжилттай сольж, гадаад богино хугацаат өрийн дарамтыг бууруулж, дотоод эдийн засагт нааштай өөрчлөлтүүд гарч эхлэв. Тухайлбал, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтворжиж, гадаадын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдийн тодорхой бус байдал арилж, итгэл сэргэв. Мөн нүүрсний экспортын өсөлт давхацсанаар эдийн засгийн идэвхжил сэргэж, 2017 болон 2018 оны эцэст эдийн засгийн өсөлт 5.3 болон 6.9 хувьтай гарчээ.

Эдийн засаг сэргэлттэй холбоотой гадаад валютын эрэлтийн өсөлттэй зэрэгцэн Холбооны нөөцийн банк 2018 онд бодлогын хүүгээ 4 удаа өсгөж 2.50% буюу Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралаас хойш хамгийн өндөр хэмжээнд

хүргэснээр олон улсад ам.долларын өгөөж өсч, хөрөнгийн урсгал хөгжиж буй орнуудаас хөгжингүй орныг чиглэж, улмаар ам.долларын ханш бусад валютын эсрэг чангарах болов. Иймд Монголбанк 2018 оны 2 дугаар хагаст валютын зах дээр үүссэн ам.долларын ханшийн огцом хэлбэлзлийг тогтворжуулах, валютын захад оролцогчдод тулгарсан нэн шаардлагатай эрэлтийг хангах чиглэлийн дагуу валютын зах дахь оролцоогоо нэмэгдүүлэв.

Түүнчлэн 2017-2018 онд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк валютын захаас 1,992.4 сая ам.долларыг худалдан авсан бөгөөд иргэд, аж ахуйн нэгжээс нийт 41.9 тонн алт худалдан авснаар 2018 оны эцэст гадаад валютын улсын нөөц 3,549.1 сая ам.долларт хүрчээ.

Дүрслэл 1. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, ГВН 1996-2018



Эх сурвалж. Монголбанк



**А.БАТСҮХ: ВАЛЮТЫН
НӨӨЦИЙН ДОЛЛАР
БҮРИЙГ "10 НҮД"
ХЯНАЖ БАЙХ
ТОГТОЛЦООГ
НЭВТРҮҮЛСЭН**

*Монголбанкны Ерөнхийлөгч асан А.Батсүхтэй
ярилцлаа.*

Юуны өмнө танд Монгол Улсад банкны салбар үүсч, хөгжсөний 95 жилийн ойн баярын мэнд хүргэе. Та Төв банкны Ерөнхийлөгчөөр 2006-2009 онд ажиллаж байсан. Таныг ажиллаж байх үед Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал ямар байв, түүнд тохируулан хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга, хэрэгслийн онцлог нь юу байсан бэ гэдгээс ярилцлагаа эхэлье.

Баярлалаа. Монгол Улсад банкны систем үүсч хөгжсөний 95 жилийн ойн баярын мэндийг банкны системийн нийт хамт олон, үе үеийн ахмадууд, Монголбанкны хамт олонд хувиасаа болон хамтран

ажиллаж байсан хамт олныхоо нэрийн өмнөөс дэвшүүлье.

2006-2009 оны үе их онцлогтой. Дотоодын төсөв, санхүүгийн бодлогын хувьд нийгмийн хавтгайрсан халамжийг ид хэрэгжүүлж байсан үе. Тэгэхээр төсвийн бодлого талаас мөнгөний бодлогод эерэг, дэм болох ямар ч боломжгүй, гадаад зах зээлийн хувьд дэлхийг хамарсан банк, санхүүгийн хямрал ид нөмөрсөн ийм л үе байсан. Дэлхийн бүх улсын төв банкууд санхүүгийн хямралд ил, далд бэлдсэн. Бид ч бас бэлдсэн. Ямар арга хэмжээг яаралтай авсан бэ гэхээр мөнгөний бодлогын голлох арга хэрэгслүүдээ сайжруулж, боловсронгуй болгосон. Тухайлбал, мөнгөний бодлогын хүүг 2007 оны

долоодугаар сарын 1-нээс дотоодын зах зээл дээр нэвтрүүлсэн. Энэ бол чанарын их өндөр ахиц авчирсан хэрэгсэл. Өмнө нь төв банкны үнэт цаасны арилжаагаар зохицуулдаг байсан харилцааг бодлогын хүү болгон, зах зээлд нэвтрүүлснээр мөнгөний бодлогыг богино, дунд, урт хугацаанд илүү чанартайгаар хэрэгжүүлэх боломж бүрдсэн. Гадаад валютын албан нөөц анх удаа нэг тэрбум ам.долларт хүрсэн. Ойролцоогоор 400 гаруй сая ам.доллараас нэмэгдсээр байгаад нэг тэрбум ам.долларт хүрсэн нь тухайн үедээ маш том амжилт байлаа. Төв банкны хувьд хуулиараа энэ нөөцийг бид аюулгүй хадгалах үүрэгтэй. Үүний дагуу Эрсдэлийн удирдлагын албыг



шинээр байгуулсан. Энэ албаны ажиллах гол зарчим нь валютын нөөцийн нэг доллар бүрийг 10 хүн хянана гэсэн үг. Хяналт, шалгалтын хувьд ОУВС, Дэлхийн банктай хамтарч санхүүгийн системийн иж бүрэн үнэлгээг анх удаа хийсэн. Үүний дагуу яаралтай болон дунд, урт хугацаанд авах арга хэмжээнүүдээ тодорхойлоод, шууд ажилдаа орсон.

Бүртгэлийн хувьд мөн шинэчлэлтүүд гарсан. Банк хоорондын төлбөр, тооцоог бодит цагийн горимд оруулж, програм хангамжийг шинэчилж, бүртгэлийн нөөц төвийг олон улсын стандартын дагуу байгуулж, ажиллуулсан. Энэ бол мэдээллийн аюулгүй байдал талаасаа чухал ажил байлаа. Хямралыг угтаж, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Төв банкны Ерөнхийлөгч нараас бүрэлдсэн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг шинээр байгуулсан. Энэ гурван хүн хуралдаж, эгзэгтэй үед авах арга хэмжээгээ тодорхойлж, зохицуулах бүтэц одоо ч ажиллаж байгаа. Санхүүгийн мэдээллийн алба мөн шинээр байгуулагдаж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуулийн дагуу ажиллаж эхэлсэн.

Тухайн үед бид боловсон хүчнийхээ нөөцөд маш их найдаж байсан. Энэ нь ч талаар болоогүй. Мэргэжлийн болон хүн чанарын хувьд хамгийн өндөр ёс суртахуунтай боловсон хүчнүүдээ дотроосоо сэлгэн байрлуулж, урд эгнээндээ томилж, маш их ачаалалтай ажилласан. Миний хувьд хамтран ажиллаж байсан хүмүүстээ маш их сэтгэл хангалуун байдаг. Үргэлж талархаж явдаг. Бид

асар өндөр ачаалалтай, хүнд хэцүү 3 жилийг ардаа үдсэн.

Өндөр ачаалалтай, богино хугацаанд ажилласан үйл явдлыг энгийнээр тоймлоод хэлбэл, та цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ хүлээжавлаагэжбодъё. Улаанбаатар хотод асар их хохиролтой, усархаг бороо бүтэн сар үргэлжилж орно гэж байна. Тэгээд юу хийх вэ гээд бод. Дотоодын байдал тийм ч таатай биш буюу хавтгайрсан халамжид ид амташсан байгаа үед ийм өндөр эрсдэл нүүрлэвэл инженерүүд хамгийн түрүүнд хотыг урсахаас хамгаалах далан байгуулна шүү дээ. Бидний хувьд маш яаралтай далан байгуулах ажилд орсонтой л адилхан юм. Асар нарийн цагийн хуваарь, маш хатуу дэглэмээр хийж гүйцэтгэсэн ажлууд гэж ойлгож болно. Тийм учраас хямралыг тухайн үеийн төв банк, Монгол Улсын Засгийн газар аж ахуйн нэгжүүд, айлын үүдээр оруулаагүй гэж үздэг. Нэг зүйлийг хэлэхэд хямралыг угтсан арга хэмжээнүүд, мөн хямралын үеэр хэрхэн ажилласан талаар манай дотоодод хангалтгүй судалсан байна. Гадаадын улс орнуудад бол хямрал юунаас болж эхэлсэн, урьдчилан сэргийлэх арга хэмжээг яаж хэрэгжүүлсэн, хямралын үеэр авсан арга хэмжээнүүд, түүний үр дүн гээд хэдэн саяар тоологдох судалгаа байна. Одоо ч судалгаанууд хийгдсээр байгаа. Бидний хувьд тухайн үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг ямар ч сурах бичгээс харах боломжгүй байсан. Яг практик дээр тулчихсан байсан үед шуурхай арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн. Энэ түүх их сургамжтай байх болов уу гэж боддог.

Таны үед төв банк анх удаа инфляцийг онилох бодлого руу шилжсэн байдаг. Энэ талаар дурсамж хувцаалцаач?

Бас л анхаарч байсан бодлогын чиглэл юм. Практик дээр төв банк ганцаараа инфляцийг онилоод, байгаа онох магадлал маш бага юм билээ. Төсвийн бодлого дэм болохооргүй чиглэл рүү явсан учраас хүлээсэн үр дүнг өгөөгүй. Энэ нь өөрөө бас нэг үр дүн. Зөрүү бодлоготой байвал байгаа онодоггүй юм байна гэдэг сургамжийг л өгсөн.

Засгийн газар тэлэх бодлого явуулаад, төв банк мөнгөний бодлогыг хатууруулах бодлого явуулахаас өөр аргагүй нөхцөл байдалд байсан байх?

Өөр хувилбар байгаагүй. Ер нь мөнгөний бодлогын хувьд нийт активын өсөлт, нийт зээлийн өсөлт гээд тоон үзүүлэлтийг шүтэх хандлага нэлээд хүчтэй болчихсон байсан. Энэ нь бас багагүй бэрхшээл учруулсан. Чанарын ахиц их чухал байсан. Зөвхөн тоон үзүүлэлтээр хүссэн үр дүндээ хүрч чадахгүй гэдэг нь ойлгомжтой байсан. Хямрал бүр сайн ойлгуулсан.

Хямралыг айлд оруулахгүйгээр хаалт хийж чадсан бодлогыг явуулсан гэж байна. Энэ үед төв банкны үнэт цаасыг нэвтрүүлж, мөнгөний эргэлтийг нэлээд сайн дэмжиж өгсөн гэж ойлгогдохоор байна?

Ямар ч байсан зохицуулалтын арга хэмжээнүүд төв банкны зорилттой нийцэж байсан.



1993 ОНЫ ШИНЭ ЗАГВАРЫН МӨНГӨН ТЭМДЭГТ

1993 оны мөнгөн тэмдэгтийн загварыг 1992 онд Улсын бага хурал баталсан бөгөөд зураг, загварын ерөнхий тоймыг Урлагийн гавьяат зүтгэлтэн зураач М.Бүтэмж, Г.Төмөрбаатар нар бүтээж, нарийвчилсан зургийг Английн мөнгөний үйлдвэрийн зураач Г.Ботвик зурсан билээ.

Шинэ мөнгөн тэмдэгтийн дэвсгэрт бүр өөр өөр өнгө, хэмжээтэй. 500, 1000, 5000, 10000-тын дэвсгэртэд Их Эзэн Чингис хааны хөрөг, 10-таас 100-тын дэвсгэртэд Д.Сүхбаатарын хөрөгтэй, Их нүүдэл, таван амтатны оргилуур, арслан зэрэг түүхэн болон бэлчиж яваа адуу, Отгонтэнгэр уул зэрэг байгалийн зураг чимэглэлтэй, хуурамчаар үйлдэхээс хамгаалсан 10-аад хийцтэй. Энэ оны мөнгөн тэмдэгтэд төрийн туг, соёмбо, Чингисийн зарлигийн гэрэгээг оруулж хэвлэсэн. Төрийн далбаатай давхцуулан "Монгол Улс" гэсэн үгийг эвхмэл монгол үсгээр бичиж оруулжээ.

Арилжааны банкууд, томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьд зөрчилтэй дүгнэлт гарч ирж болно. Тэгэхээс ч өөр аргагүй. Дэлхийн хямралаас болж, стандарт бус нөхцөл байдалд орсон шүү дээ. Жишээ нь гадаадын хөрөнгө оруулалт маш ойлгомжтой шалтгаанаар зогссон. Ийм үед төлөвлөгөөгөө өөрчилж ажиллах бус шаардах, хэн нэгнийг буруутгах бол хэвийн үзэгдэл байсан. Үүнийг бид тооцож байсан учраас тайлбарлаад, хариу арга хэмжээнүүдээ зогсолтгүй авч хэрэгжүүлж ирсэн.

Санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, банкны хяналт, шалгалтыг сайжруулах нь бас их чухал байсан байх. Тухайн үед энэ чиглэлээр төв банк хэрхэн ажилласан бэ?

Базелийн хорооны зарчмуудыг шинээр нэвтрүүлсэн. Салбарын хувьд бас л их эмзэг хүлээж авсан. Гэхдээ нийт салбарын эрх ашгийн төлөө хэрэгжүүлсэн учраас ойлгосон. Хамгийн гол нь олон улсын стандартын дагуу хяналт, шалгалтын ажлыг эхлүүлж байгаа учраас үүнд мэргэжилтнүүдийн их өндөр уран чадвар шаардсан. Өдөр тутамд хүнд ажлууд их олон гарч байсан. Сайн мэргэжилтнүүд, туршлагатай хүмүүс, төрийн албан хаагч нар зөв шийдвэр гаргаж, ажилласан гэж боддог.

Таныг ажиллаж байх үед төв банкны бие даасан бодлого явуулах нөхцөл байдал тухайн үед ямар түвшинд байсан бэ?

Ямар арга хэрэгсэл нэвтрүүлэх вэ гэдгээ төв банк хэнээс ч хамаарахгүй шийдэж байсан. Мөнгөний бодлогын хүү нэвтрүүлэх гэж байна

гэдгийг хэнээс ч асуух шаардлагагүй. Түүгээрээ шийдсэн. Эрсдэлийн удирдлагын алба байгуулах, ийм програмыг шинэчлэх, ийм горимд шилжих ёстой гэдгийг хэнтэй ч хуваалцахгүйгээр шийдэж л байсан. Гол асуудал юунд байсан бэ гэхээр миний үед ч байсан, одоо ч байсаар байгаа. Төв банкны бие даасан байдлыг сайжруулах гол шалгуур нь миний хувьд эдийн засгийнхаа бүтцийг сайжруулах л асуудал гэж хувьдаа дүгнэдэг. Тэгэхгүйгээр инфляцийн тоон үзүүлэлтийг Их хурал, Засгийн газартай ярих нь дарааллын хувьд нэлээн хойно яригдах асуудал. Өнгөрсөн үеийн тоон үзүүлэлт, ирээдүйн прогноз гаргадаг. Бид үүнийг гаргадаг сайн аргуудтай. Дэлхийн аль ч төв банкинд гологдохооргүй хийж чадна. Энэ нэг өөр зүйл. Үүнээс гадна хамгийн чухал нь эдийн засгийнхаа бүтцийг сайжруулж байж л төв банкны бие даасан байдлыг сахина. Эдийн засгийн бүтэц сул байгаа учраас өнөөдөр зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох, итгэлийн зээл олгох гэх зэрэг популист сэдэв гарч ирээд байна. Цаашдаа ч маш гоё нэртэй саналууд байнга гарна. Бид үүнийг тооцоолох, таамаглах аргагүй. Гарч байгаа шалтгаан нь бизнесийн орон зай хавчигдмал, тамирчнаар бол хүчил төрөгчийн хангамж их дутагдалтай байна. Үүнийг нэмэгдүүлэх гол ажил нь төрийн албанд л бий. Өөр хэн ч хийж чадахгүй, сонирхохгүй. Хамгийн гол нь энэ ажил цалин хангамж багатай, их олон жил зүтгэж байж хийх ажил юм.



“**2006–2009 оны үе их онцлогтой. Дотоодын төсөв, санхүүгийн бодлогын хувьд нийгмийн хавтгайрсан халамжийг ид хэрэгжүүлж байсан үе. Тэгэхээр төсвийн бодлого талаас мөнгөний бодлогод эерэг, дэм болох ямар ч боломжгүй, гадаад зах зээлийн хувьд дэлхийг хамарсан банк, санхүүгийн хямрал ид өрнөсөн ийм л үе байсан. Дэлхийн бүх улсын төв банкууд санхүүгийн хямралд ил, далд бэлдсэн. Бид ч бас бэлдсэн. Ямар арга хэмжээг яаралтай авсан бэ гэхээр мөнгөний бодлогын голлох арга хэрэгслүүдээ сайжруулж, боловсронгуй болгосон.**”

Эдийн засгийн бүтцийг сайжруулсан цагт сонгодог төв банк төлөвших нөхцөл бүрдэнэ гэсэн үг үү?

Тийм боломж илүү ихээр бүрдэнэ. Онолын хувьд ч тэр, практикийн хувьд ч тэр одоогийнх шиг бэрхшээл гарахгүй. Миний түрүүн хэлсэн шиг сэдвүүд гарах орон зайгүй болно. Эдийн засгийн бүтцээ тэлж, сайжруулахгүй байгаа учраас л цаашдаа янз бүрийн сэдвүүд маш их гарах болов уу гэсэн болгоомжлол байна. Асуудал нь эдийн засгийн бүтцэд байгаа юм. Төв банк, эсвэл Сангийн яам, Эдийн засгийн байнгын хороонд асуудал байгаа юм биш.

Цаашид мөнгөний бодлогоо оновчтой хэрэгжүүлэхэд голлон анхаарах зүйл таны бодлоор юу байна вэ?

Цаашид, ойрын ирээдүйд төв банк юун дээр анхаараасай гэж хүсч байна вэ гэхээр мөнгөний бодлогын томъёолол, хэрэгжилт дээр шаардаж, тулгасан шинжтэй маш олон сорилт гарч ирэх байх. Дээр нь эдийн засгийн бүтцийг чанаржуулах урт хугацааны хүнд ажилтай холбогдуулаад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдээ сайжруулах боломжийг байнга л судалж байх ёстой. Жишээлбэл, инфляцийн хүлээлтийг мөнгөний бодлогын нэг арга хэрэгсэл болгох судалгааг аль болох эрчимтэй эхлээсэй гэж боддог. Бодлого боловсруулагчид, эсвэл томоохон аж ахуйн нэгжүүд, энгийн иргэдээс инфляци, мөнгөний бодлогын талаар ярьж хэлж байгаа бүх зүйлийг шинжлээд, программаар үнэлнэ гэсэн үг. Хүлээлт ийм байна, өсөх хандлагатай байна гэдэг ч юм уу. Эсвэл зохисгүй, зохиомол,

санаатайгаар түгээж байгаа мэдээлэл хүлээлтэд ингэж нөлөөлж байна гэдгийг тодорхойлох юм. Үүнийг үнэлж чадвал бид хариу арга хэмжээг төлөвлөж чадна. Манай монголчуудын хувьд нийслэлд хүн амын тал шахам хувь нь амьдарч байна. Мөн 50 шахам хувь нь сошиал сүлжээнд маш идэвхтэй ажиллаж байна гэдэг нь хүлээлтийг зөв удирдах боломж аль аль талдаа тэнцүү гараад ирчихсэн байгаа юм. Тэгэхээр хүлээлтийг удирдах мөнгөний бодлогын хэрэгсэл төв банк үүссэний 95, 100 жилийн үеэр бий болчихсон байгаасай л гэж хүсч байна. Маш их судалгаа хэрэгтэй. Хэл шинжлэл хүртэл орно. Судлаачдын хувьд ч толгой гашилгасан ажил юм. Их хурлын гишүүд, топ аж ахуйн нэгжүүдийн хэлж байгаа бүх зүйл бүртгэж, үнэлэх чиглэлийн програмуудыг хөгжүүлж байна. Бидний хувьд сошиалд идэвхтэй амьдралтай болчихсон учраас тооцохгүй байж болохооргүй талбар үүссэн байна. Тийм учраас зөвхөн хяналт, шалгалт гэлгүйгээр, сошиал ертөнцөөр дамжуулан инфляцийг буруу, эсвэл зөв тал руу нь удирдах бүрэн боломжтой юм. Энэ хүнд ажил л даа. Гэхдээ хийх л ёстой.

Ярилцсанд баярлалаа.



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР, АРГА ХЭРЭГСЛҮҮД

Худалдаа, аж үйлдэрийн банк (Монголбанк) 1924 онд үүсгэн байгуулагдсанаас хойш банкны нэг шатлалт тогтолцоогоор 70 орчим жил явж ирсний дараагаар банкны хоёр шатлал бүхий тогтолцоо руу шилжив. Хоёр шатлалт банкны систем үүссэн үе буюу 1990 оны эхэн үед Төв банкнаас аж ахуйн харилцааг тасалдуулахгүй байх үүднээс банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах, байнга өсч буй үнийн өсөлтөд шаардагдах эх үүсвэрийг гаргах шаардлагатай байсан тул мөнгөний бодлогын гол хэрэгслүүд нь Төв банкнаас эх үүсвэр олгох хэлбэртэй байв.

УИХ-аас 1996 онд Төв банк / Монголбанк/-ны тухай хуулийг баталж, мөнгөний бодлогын зорилгоор хэрэглэж болох хэрэгслүүдийн хүрээг тогтоон хуульчлав. Улмаар 1993 оноос эхлэн туршиж байсан Төв банкны үнэт цаас гэх хэрэгслийг мөнгөний нийлүүлэлтийн хэмжээг тохируулан удирдах гол хэрэгсэл болгон ашиглаж байв. Гэвч тухайн үед арилжааны банкууд анх удаа системийн хэмжээний хямралд өртөж, санхүүгийн зуучлал дахин хязгаарлагдмал болов. Үүнийг дагаад төлбөрийн чадвар нь муудсан банкуудын зээл олголтод хязгаар тогтоох ажлыг үргэлжлүүлсэн нь нийт банкинд

бус, хүндрэлд орсон банкуудад л хамаатай байсан тул мөнгөний бодлогын хэрэгсэл бус банкны хяналт шалгалтын хэрэгслийн үүрэг гүйцэтгэж байжээ. Энэ үед Төв банк алт худалдан авах, гадаад валютын захад идэвхтэй оролцох зэргээр байнга мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж байсан тул Төв банкны үнэт цаас (ТБҮЦ) ашиглан мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг хязгаарлах байдлаар бодлогын хэрэгслүүдийг ашиглаж байв. Үүний дараагаар Монголын эдийн засаг харьцангуй тогтворжихын хэрээр бодлогын хэрэгслүүд зах зээлд суурилсан арга хэрэгсэл рүү шилжиж, бодлогын үйл ажиллагааны зорилтоор нөөц мөнгө, завсрын зорилтоор мөнгөний нийлүүлэлтийг хянах замаар эцсийн зорилт болох инфляцийн түвшинг бууруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэв.

Монголбанк үйл ажиллагааны зорилт болох нөөц мөнгөний өсөлтийг өөрчлөхдөө заавал байлгах нөөц, ТБҮЦ, дахин хямдруулалтын зээл, дахин санхүүжилтийн зээл клирингийн зээл болон эх үүсвэрийн дутууд олгох зээл зэрэг бодлогын хэрэгслийг ашиглаж байв. Харин мөнгөний үзүүлэлтийг онилох явцад мөнгөний агрегат болон инфляцийн хоорондох хамаарал тогтворгүй болж эхэлсэн зэрэг хүчин зүйлээс шалтгаалж 2007

оноос эхлэн мөнгөний бодлогын шинэ арга хэлбэрт аажмаар шилжиж мөнгөний захын хүүнд нөлөөлөх байдлаар инфляцийг онилох мөнгөний бодлогод шилжих бэлтгэл ажлыг хангаж эхлэв.

Инфляцийг онилох мөнгөний бодлогын арга хэлбэрт шилжихэд: нэгдүгээрт; бодлогын үйл ажиллагааны зорилтыг өөрчилж, банк хоорондын захын хүүг нэвтрүүлэх, хоёрдугаарт; бодлогын нөлөөллийн шинжилгээ болон төсөөлөл хийх чадавхыг хөгжүүлэх шаардлагатай байв. Хүүгийн түвшинг ашиглан бодлого хэрэгжүүлэх шийдвэрийг 2007 оны 7 дугаар сарын 4-ний өдөр гаргаж, тухайн үед бодлогын гол хэрэгсэл болж байсан долоо хоногтой ТБҮЦ-ны хүүг бодлогын хүү байхаар сонгов. Мөнгөний бодлогын хэрэгслүүд дэх хүүгийн түвшнүүдийг нийцтэй болгож, хэрэгслүүдийн үр ашгийг сайжруулах шаардлага нь "Бодлогын хүү" ашиглаж эхэлснээр улам чухал болов. Ийнхүү бодлогын шийдвэр нь Монголбанкны банкуудтай хийх бүх хэлцлийн хүүг бодлогын хүүтэй уялдуулан тогтоох хүүгийн коридорыг бий болгосон нь бодлогын хэрэгслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх томоохон алхам болжээ. Ингэснээр инфляцийг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах зорилттой



нийцтэй бөгөөд макро эдийн засгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хадгалахад чиглэх байдлаар бодлогын хүүг тогтоох шийдвэрүүд хийгдэж байна.

Сүүлийн жилүүдэд иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт өндөр түвшинд хүрч, өрхийн өрийн түвшинг нэмэгдүүлж байна. Санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалж, мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, Монголбанк санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлоготой хослуулан хэрэглэхээр Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлд тусгав. Энэ хүрээнд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор макро зохистой бодлогын шийдвэрийг Мөнгөний бодлогын хорооноос 2018 онд гаргаж, 2019 оноос хэрэгжүүлж эхлэв.

Зах зээлийн эдийн засагт шилжсэн эхний жилүүдэд хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляци 1993 онд 400 гаруй хувьд хүрч байв. Иймээс Төв банк үнийн өсөлтийг сааруулах арга хэмжээнүүдийг авснаар 1998 оны хоёрдугаар хагаст инфляци 1 оронтой тоонд хүрч бууран үүнээс хойш 10 хувийн орчимд байлаа. Харин 2008 оны дэлхийн санхүүгийн хямрал нь манай улсын эдийн засагт сөрөг нөлөө үзүүлснээр импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөөр дамжин инфляци 2008 онд эрчимтэй нэмэгдэж 30 гаруй хувьд хүрч байсан бол 2016 онд эдийн засаг агшиж, иргэдийн

худалдан авах чадвар буурч эрэлт багассанаас үүдэн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ унах буюу дефляцитай болж байлаа. Үүнээс хойш эдийн засгийг сэргээх бодлогуудыг хэрэгжүүлж, хэрэглэгчдийн худалдан авах чадамж сайжирч эрэлт нэмэгдсэнээр хэрэглээний үнэ 2017 онд нэмэгдэж 8 хувийн орчимд очсон бөгөөд үүнээс хойш инфляци Төв банкны зорилтод түвшний (8 хувь) орчимд байна (Дүрслэл 1).

Инфляцийн гүйцэтгэлд илэнхдээ зорилтод түвшнээс давж байсан нь мөнгөний бодлогоор нөлөөлөх боломжгүй хүчин зүйлсийн буюу зах зээлийн бүтэц, улирлын нөлөө зэрэг нийлүүлэлтийн шинж чанартай өөрчлөлтөөр хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ нэмэгдэх хандлага буурахгүй, харин ч нэмэгдэж байсантай холбоотой юм. Тухайлбал, цаг агаарын таагүй байдлаас шалтгаалан зах зээл дээр мах, сүү, хүнсний ногоо зэрэг өргөн хэрэглээний барааны нийлүүлэлтийг доголдуулж, үнэ өсөх нөхцөлийг бүрдүүлж байна. Түүнчлэн манай эдийн засгийн уул уурхайгаас хамаарах хамаарал нэмэгдэх хирээр гадаад шокийн инфляцид үзүүлэх нөлөө сүүлийн 20 гаруй жил буурахгүй байна. Энэ нь өрхийн

хэрэглээнд өндөр жин эзэлдэг импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг нэмэгдүүлж байна. Бэлэн мөнгө тараах амлалт 2004 оны УИХ-ын сонгуулиас эхлэн нэмэгдэж, хүүхдийн мөнгө нэрээр бэлэн мөнгө анх 2006 оноос олгож эхлэв. Хожим нь энэ үйл явц улам хүрээгээ тэлж хүүхдийн мөнгө нь бүх иргэдэд олгох мөнгөн тэтгэмж болсны зэрэгцээ нэмж олон төрлийн мөнгөн тэтгэмжийг төсвөөс санхүүжүүлж эхэлсэн нь эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамтыг нэмэгдүүлэх нөлөөг үзүүлэв. Нөгөө талаас Монголбанк төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхэд их хэмжээтэй мөнгийг 2012-2016 онд банкны секторт шинээр нийлүүлж байсан нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрахад шууд болон шууд бусаар нөлөөлж, дотоод эрэлтийг өдөөх замаар үнийн өсөлтийг нэмэгдүүлэх нөлөөг үзүүлэв. Эцэст нь төсвийн бодлогын төлөв байнга сул буюу 2008-2017 онд төсөв тогтмол алдагдалтай гарч байсан нь дотоод эрэлт, улмаар инфляцийг нэмэгдүүлэх дарамтыг байнга хадгалж ирсэн нь инфляци төдийгүй макро тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Дүрслэл 1. Инфляци, түүний зорилт: 1999-2018



Эх сурвалж. Монголбанк



“Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд зааснаар”

Монголбанкны үндсэн зорилт нь
үндэсний мөнгөн тэмдэгт-
төгрөгийн тогтвортой байдлыг
хангахад оршино.



1

Мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх



2

Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн
үүрэг гүйцэтгэх



3

Үндэсний төлбөрийн систем, түүний үйл
ажиллагааг удирдах, зохицуулах, хянах



4

Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн
ашиг сонирхлыг хамгаалах



5

Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, зохицуулах



6

Банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн
үйл ажиллагаанд хяналт тавих



7

Гадаад валютын улсын нөөцийг эзэмших,
удирдах



8

Макро зохистой бодлого хэрэгжүүлэх



ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Цааснаас цахимжсан нь

Монгол Улс хоёр шатлалт банкны тогтолцоонд шилжсэн үеэс Монголбанк нь банк хоорондын клирингийн тооцоог зохион байгуулах арга хэмжээг авах болов. Ингэснээр банк хоорондын төлбөр тооцоог кредит болон дебет авизо буюу цаасан баримтанд үндэслэн гүйцэтгэх болсон байна. Банк хоорондын төлбөр тооцооны энэхүү ажиллагааг 1993 онд шинэчлэн харилцаа холбоо ба мэдээллийн технологид суурилсан дэд бүтцээр дамжуулан гүйцэтгэх болсон нь Монгол Улсад үндэсний төлбөрийн систем үүсч хөгжих эхлэл тавигджээ.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хууль 1995 онд батлагдсанаар бэлэн бус төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, чек, вексель, төлбөрийн карт болон төлбөрийн бусад баримтаар гүйцэтгэх болов. Векселийн тухай хууль батлагдан гарсан нь бэлэн бус төлбөр тооцооны хамрах хүрээг өргөжүүлж, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд чухал алхам болсон юм. Энэ үеэс эхлэн банк хоорондын

гүйлгээг өдөрт 2 удаа тогтмол цагуудад хүлээн авч, хуваарилах, банк хоорондын гүйлгээний өдрийн эцэст үр дүнгийн тооцооллыг тогтсон цагт нийлж тохируулж байсан. Арилжааны банкны төвүүдийг нэгдсэн цахим сүлжээнд холбосон төдийгүй 1997 онд Монголбанк нь арилжааны банкуудын нягтлан бодох бүртгэлийн хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор банк хоорондын клирингийн тооцооны журмыг шинээр баталсан. Мөн онд Монголбанк олон улсын төлбөр тооцооны СВИФТ¹ сүлжээнд холбогдсоноор гадаад төлбөр тооцоог шуурхай дамжуулж, гадаад улс орнуудтай хийх гүйлгээний найдвартай байдал хангагдах болов.

Төлбөр тооцооны системийг шинэчлэх ажлын хүрээнд 2006 онд одоогийн Үндэсний цахим гүйлгээний төв (цаашид ҮЦГТ гэх)-ийг байгуулж, банкуудын төв болон Сангийн Яамны Төрийн сангийн газар, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийг

¹ Олон улсын банк санхүүгийн байгууллагын хооронд санхүүгийн мэдээг дамжуулдаг цахим сүлжээ.

санхүүгийн дундын сүлжээнд холбож, улмаар эдгээр оролцогчид өөрсдийн төлбөр тооцоог бодит цагийн горимоор дамжуулж, хянах боломж бий болов. Тус системийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Монголбанкнаас 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн тушаалаар "Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам", "Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журам"-ыг тус тус батлан, мөрдүүлж эхэлсэн. Банк хоорондын гүйлгээг их, бага гэж мөнгөн дүнгээр нь ялган хоёр системийг нэгэн зэрэг ашиглах болсон бөгөөд энэ дэвшил нь Монгол Улсын төлбөрийн системийн үр ашигтай, найдвартай байдлыг бэхжүүлэх чухал алхам болов.

Монголбанк нь банк хоорондын их дүнтэй гүйлгээг бодит цагийн горимд дамжуулах "Банксүлжээ" системийг 2009 онд нэвтрүүлэв. Энэ нь их дүнтэй буюу 1 сая төгрөг ба түүнээс дээш дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог боловсруулах хугацааг багасгах, гүйлгээ дамжуулах бүх шатанд төлбөрийн мэдээлэл бүрэн байх,



нууцлал аюулгүй байдлыг хангах, харилцах дансны үлдэгдэлд бодит цагийн горимд хяналт тавих боломжийг төлбөрийн системийн нийт оролцогчдод (банкууд болон Сангийн яамны Төрийн сангийн газар, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв) олгосноор банкуудын эх үүсвэрийн үр ашгийг нэмэгдүүлэх, төлбөрийн үл буцаагдах байдлыг хангах ач холбогдолтой арга хэмжээ болов. “Банксүлжээ” системээр банк хоорондын төлбөр тооцоог дамжуулахаас гадна оролцогчид бусад санхүүгийн мэдээ, тайланг харилцан солилцох боломжтой юм. Мөн тус системээр DvP болон PvP зарчмыг ашиглан үнэт цаасны болон гадаад валютын төлбөр тооцоог гүйцэтгэж болох давуу талтай юм.

Монголбанк нь Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг бэлгэдэн нэрлэсэн үндэсний брэнд “₮ карт”-ыг банкуудтай хамтран гаргах ажлыг амжилттай зохион байгуулж, 2012 онд нийтийн хүртээл болгосноор картын тоо 2018 оны эцсийн байдлаар 3.1 саяд хүрээд байна.

Банк хоорондын бага дүнтэй гүйлгээ нь илгээгч банк болон хүлээн авагч банкин дээр хүлээгдэж, хугацааны хоцрогдолтой гүйцэтгэдэг байсныг 2014 онд бодит цагийн горимд оруулснаар гүйлгээ хийгдсэн тухай бүрт төлбөр хүлээн авагч мөнгийг өөрийн дансандаа хүлээн авах боломжтой болов. Энэ нь Монгол Улсын төлбөрийн системийн цаашдын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, бага дүнтэй гүйлгээний бодит цагийн горимд суурилсан шинэ төрлийн төлбөрийн үйлчилгээнүүд бий болж, финтек байгууллагууд хурдтай хөгжих үндэс суурь болжээ.

Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд 2015 онд байгуулсан “Төлбөрийн системийн шинэчлэл” төсөл хэрэгжиж эхэлсэн бөгөөд төслийн хүрээнд Үндэсний төлбөрийн системийг бүхэлд нь шинэчлэн сайжруулах, шинэ дэвшилтэд үйлчилгээ нэвтрүүлэх ажлууд хийгдсээр байна.

Монгол Улсад төлбөрийн системийн үйл ажиллагааг бүхэлд

нь зохицуулах хууль эрх зүйн зохицуулалт бүрэн бүрдээгүй байсан тул Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн хүрээнд банк хоорондын төлбөр тооцоог Монголбанк зохион байгуулж, зөвхөн банкуудын үзүүлж буй төлбөрийн үйлчилгээнд хяналт тавьдаг байв. Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн даган шинэчлэгдэж байгаа төлбөрийн системийн үйл ажиллагаа, үүнтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах эрх зүйн орчинг бий бүрдүүлэх зорилгоор Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төслийг Монголбанкнаас санаачлан батлуулж, 2018 оноос хүчин төгөлдөр мөрдөж эхлэв. Тус хуульд төлбөрийн системийг бүхэлд нь хянах, зохицуулах, зөвшөөрөл олгох, хариуцлага тооцох тухай зааж оруулсан бөгөөд хуулийн зохицуулалтын хүрээ нь зөвхөн банк, банк бус санхүүгийн байгууллагаар хязгаарлагдахгүй, төлбөрийн системд бусад хуулийн этгээд, компани оролцох боломжийг анх удаа нээснээрээ онцлог юм.



ТҮҮХЭН ХӨГЖИЛ

- 1995 онд Төлбөрийн хэрэгслийг хуульчлав.
- 1996 онд SWIFT сүлжээнд холбогдов.
- 2006 онд Үндэсний цахим гүйлгээний төвийг байгуулав.
- 2009 онд Төлбөрийн картын нэгдсэн сүлжээг байгуулав.
- 2009 онд RTGS Их дүнтэй төлбөрийн "Банксүлжээ" системийг нэвтрүүлэв.
- 2012 онд Үндэсний брэнд ₮ карт гаргав.
- 2014 онд Бага дүнтэй төлбөрийн систем 24/7, бодит цагийн горимд шилжэв.
- 2016 онд Банк хоорондын интернэт худалдаа "eCommerce" нэвтрүүлэв.
- 2016 онд Төлбөрийн системийн шинэчлэл төслийг хэрэгжүүлж эхлэв.
- 2017 онд "Үндэсний төлбөрийн системийн тухай" хууль батлагдав.
- 2018 онд Цахим мөнгөний зөвшөөрлийг олгов.



Утас: 976-11-310081
 ВеБ: www.mongolbank.mn
 E-mail: info@mongolbank.mn
 Хаяг: Бага тойруу-3, 15140
 Улаанбаатар-46, Монгол Улс

ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

ЦАХИМ ЭРИНД
 ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО



МОНГОЛБАНК



Иргэн, хуулийн этгээдийн хооронд мөнгөн хөрөнгийг шилжүүлэхэд оролцох байгууллага, ашиглах төлбөрийн хэрэгсэл ба техник, технологийн дэд бүтэц, эдгээрийг зохицуулсан хууль тогтоомжийг бүхэлд нь төлбөрийн систем гэнэ.

1. ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛ



2. ХУУЛЬ, ЖУРАМ



Үндэсний төлбөрийн системийн тухай хууль
 Монголбанкнаас баталсан дүрэм, журам.

3. ДЭД БҮТЭЦ



4. ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ




Банк, зөвшөөрөл бүхий Банк бус санхүүгийн байгууллага, ба Финтек компани

ХЭРЭГЛЭГЧ



- Иргэд
- Хуулийн этгээд

ТӨЛБӨРИЙН КАРТЫН ХЭРЭГЛЭЭ



Картаар төлбөр гүйцэтгэх нь АТМ-аас бэлэн мөнгө авахаас илүү болсон.

ТӨЛБӨРИЙН КАРТЫН ЗАХ ЗЭЭЛ





Төв банкны ХАРААТ БУС БАЙДАЛ яагаад чухал вэ?

ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Аливаа төв банкны үйл ажиллагааны үр дүнг түүний зорилтдоо хүрч байгаа байдлаар хэмждэг билээ. Харин төв банк зорилтдоо хүрэх, үйл ажиллагаа нь хэвийн үргэлжлэхэд нөлөөлдөг томоохон хүчин зүйл нь төв банкны хараат бус байдал юм. Төв банкууд анх XVII зуунд байгуулагдахдаа хувийн өмчлөлийн хэлбэртэй, иргэдээс хөрөнгө татаж, хариуд нь баталгаа болгон үнэт цаас буюу мөнгөн тэмдэгт гаргадаг, нөгөө талд нь засгийн газарт зээл олгох хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байв. Орчин үед төв банкууд нь улс орны мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, эдийн засаг болон санхүүгийн тогтвортой байдлыг хангадаг институци болж хөгжсөн.

XX зуунд төв банкуудыг нийгэмчилж, төрийн мэдэлд шилжүүлсний дараа тулгарсан нэг хүндрэл нь Засгийн газрын эрх

мэдэл, оролцоо хэт өндөр байсны улмаас инфляци хурдтайгаар өсөж байв. Ялангуяа 1970-аад онд АНУ, Их Британи зэрэг дэлхийн тэргүүлэх эдийн засаг, санхүүгийн хөгжилтэй орнуудад инфляци 2 оронтой тоонд хүрч иргэдийн худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөв. Төв банк нь Засгийн газартай хэт ойр байж, эрх мэдэлд автах нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар инфляцийг өсгөх аюултай. Энэ асуудлын гаргалгаа болгож 1990-ээд оноос Шинэ Зеланд, Чехийн Төв банкууд үйл ажиллагаандаа хараат бус байдлыг нэвтрүүлсэн. Улмаар Их Британи, АНУ, Европын Төв банкууд энэ жишгийг дагаснаар өдгөө Төв банкны үйл ажиллагаанд томоохон ахиц буюу түүхэн шинэ хуудсыг нээсэн юм.

Өдгөө төв банк хараат бус байх нь зүйтэй гэдэг үзэл олон улсын жишиг болж тогтоод байна. Төв банкны бодлогын шийдвэр нь ихэвчлэн ирээдүйд чиглэсэн, дунд урт хугацаанд эдийн засгийн

тогтвортой байдлыг хангах зорилготой байдаг. Тиймээс ч зарим тохиолдолд төв банкны бодлого нь богино хугацаанд хэрэглээг танах буюу эрсдэл хуримтлагдахаас сэргийлсэн, "консерватив" хандлагатай байдаг бөгөөд ийм бодлого хэрэгжүүлж байгаа үед бусдаас дарамт шахалт ирэх нөхцөл байдал үүсдэг. Тиймээс улс орнуудад төв банкны хараат бус байдлыг хуулиар баталгаажуулдаг болов.

ХАРААТ БУС БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Төв банкны хараат бус байдлыг тодорхойлж, хэмжих нь өөрөө шат дараалсан судалгаа шинжилгээ бүхий үйл ажиллагаа бөгөөд тооцоолоход хэд хэдэн арга аргачлалуудыг ашигладаг. Тэдгээрийн дундаас мэдээллийг тоон хэлбэрт шилжүүлж шинжлэхэд дөхөм болгодог CWN, GMT, LVAW индексийн аргуудыг ашиглах нь түгээмэл. Эдгээр аргуудын хувьсагчид, хэмжигдэхүүнүүд нь



хоорондоо зарим талаар өөр ч зарчмын хувьд үндсэн гурван ойлголтын хүрээнд ажилладаг. Тэдгээрээс дурдвал зорилгын хараат бус байдал, арга хэрэгслийн хараат бус байдал, үйл ажиллагааны хараат бус байдал юм.

Зорилгын хараат бус байдал: Энэ нь төв банкны үндсэн зорилтыг хэн тодорхойлдог, зорилт нь хэр тодорхой эсэхийг хэмждэг. Улс орнуудын төв банкууд нь ихэнхдээ "үнийн тогтвортой байдал"-ыг үндсэн зорилтоо болгодог. Тухайлбал судалгааны үр дүнгээс үзэхэд 94 орны төв банкуудын 85 нь үнийн тогтвортой байдлыг зорилтоо болгодог. Харин үнийн тогтвортой байдлыг ярих үед инфляцийн зорилтыг хаанаас тодорхойлох нь чухал хэмжүүр болдог. Английн Төв банкны инфляцийн зорилтыг Засгийн газраас нь тодорхойлдог бол АНУ-ын Холбооны нөөцийн банкны инфляцийн зорилтыг Конгрессоос тодорхойлдог. Энэ нь төв банк өөрийн зорилтоо үе үе өөрчилж, нийтийн эрх ашгийг хохироох эрсдэлээс хамгаалдаг. Монгол Улсын төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг УИХ-аас жил бүр хэлэлцэж, баталдаг. Энэ замаар инфляцийн зорилтыг хөндлөнгийн субъект тодорхойлж байгаа нь олон улсын жишиг юм. Гэхдээ дунд, урт хугацаанд хэрэгжих ёстой мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг жил бүр УИХ-аар хэлэлцэж байгаа нь өөрөө бодлогын тууштай байдалд хүндрэлийг бий болгож байна.

Монголбанкны үндсэн зорилт нь салаа утгатай тайлбарлагддаг нь хараат бус байдлыг хэмжиж тодорхойлоход оноо алддаг нэг шалтгаан болж байна.

Монголбанкны үндсэн зорилт нь "үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино" гэж байгаа нь төгрөгийн дотоод үнэ буюу инфляци, гадаад үнэ буюу ханшийн тогтвортой байдлыг давхар хангах утгыг илэрхийлдэг. Судалгаануудаас үзэхэд олон зорилттой төв банкуудын гүйцэтгэл нь цөөхөн буюу тодорхой зорилттой банкуудынхаас сул байдаг. Иймд зорилтыг илүү нарийвчилж, нэг утгаар тайлбарлах боломжтой болгож, төв банкинд үнийн тогтвортой байдлыг хангах үүргийг ногдуулах нь илүү ач холбогдолтой. Угаас Монгол Улсын хэрэглээний сагсны бүтээгдэхүүнүүдийн 40 орчим хувь нь импортын бүтээгдэхүүн байдаг учраас инфляцийг тогтворжуулахын тулд ханшийг анхаарах нь зайлшгүй юм.

Арга хэрэгслийн хараат бус байдал: Энэ нь төв банк зорилтоо хангахын тулд ямар арга хэрэгслүүдийг ашиглаж байгааг хэмждэг. Мөнгөний бодлогыг үр ашигтай хэрэгжүүлэхэд бодлогын хэрэгслүүдээс сонгох шаардлага тулгардаг бөгөөд энэ нь төв банкны бүрэн эрх мэдлийн асуудал. Нөгөөтээгүүр, бодлогын шийдвэрийг ямар зарчмаар гаргаж байгаа нь арга хэрэгслийн хараат бус байдлын нэг хэмжигдэхүүн болдог. Төв банкны бодлогын шийдвэр гаргах процесс нь засаглалын зарчмыг хэрэгжүүлж, хөндлөнгийн нөлөөгүй байх ёстой. 2018 онд Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд орсон нэг чухал дэвшил нь мөнгөний бодлогын болон хяналт шалгалтын шийдвэрийг хамтын удирдлагын зарчмаар гаргадаг болсон явдал юм. Монголбанкны мөнгөний бодлогын хорооны

үйл ажиллагааг урд өмнө нь хуульчилж өгөөгүй байсан. Өмнө нь мөнгөний бодлогын шийдвэрийг зөвлөлийн гишүүдийн зөвлөмжийг үндэслэн Ерөнхийлөгч дангаараа гаргадаг байсан. Харин хуульд нэмэлт өөрчлөлт орсноор 7 хүний бүрэлдэхүүнтэй хорооны бүтцийг бий болгож, гишүүд тус бүр нь саналын тэгш эрхтэйгээр шийдвэр гаргах процесст оролцдог болсон.

Үйл ажиллагааны хараат бус байдал: Энэ нь төв банкны удирдлагыг томилж байгаа механизм, үйл ажиллагааны санхүүжилтийг хэрхэн шийдэж байгааг тодорхойлж, хэмждэг. Үйл ажиллагааны хараат бус байдлыг заримдаа удирдлагын болон санхүүгийн хараат бус байдал хэмээн нэрлэх явдал бий. Мөнгөний бодлогын хорооны гишүүдийг үндэслэлгүйгээр чөлөөлөөд байвал мэргэжлийн түвшинд, хараат бус ажиллаж чадахгүй. Нөгөө талаар ийм зүйл олон давтагдах үед төв банкинд итгэх итгэл сулрах аюултайгаас гадна хорооны гишүүд олон солигдох нь үйл ажиллагааны зарчмыг алдагдуулах эрсдэлтэй. Монголбанкны үйл ажиллагааны хараат бус байдлыг хэмжих үед бүрэн эрхийн хугацаагаа дуусгасан Ерөнхийлөгч ердөө 1 байна. Энэ нь эргээд оноо алдах шалтгаан болдог.

Санхүүжилтийн хувьд төв банкыг үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцөл бололцоог хангах ёстой. Хэрэв санхүүгийн хувьд хэн нэгнээс, ялангуяа Засгийн газраас хамааралтай бол бодлогын арга хэрэгслийг ашиглах, санхүүжилтийг хийхэд хүндрэл тулгардаг. Монголбанк 2012-2016 онд төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлж, зээлээр гадаад



валютын албан нөөцийг нэмэгдүүлж байсан нь алдагдлыг 3 их наяд төгрөг хүртэл өсгөсөн байдаг. Хэдийгээр Монголбанк нь ашгийн төлөө бус төрийн байгууллага ч гэлээ ийм хэмжээний алдагдалтай удаан ажиллавал Засгийн газраас санхүүжилт авч хараат бус байдлаа алдах, эсвэл бодлогын хэрэгслүүдээ бүрэн ашиглахгүй байх эрсдэл үүсч болзошгүй. Тиймээс ч Монголбанк хуримтлагдсан алдагдлаа буруулахад анхаарч 2018 оны эцэст 1.8 их наяд төгрөгт хүргэсэн.

ИЛ ТОД БАЙДАЛ БА ХАРААТ БУС БАЙДЛЫН ҮР НӨЛӨӨ

Төв банкны хараат бус байдлыг дагаж урган гардаг нэг чухал ойлголт бол ил тод, нээлттэй ажиллах зарчим. Төв банкны ил тод байдал нь засаглалын нэг элемент бөгөөд нөгөө талаас олон нийттэй

харилцах харилцаа нь бодлогын нэг хэрэгсэл болдог. Тиймээс Монголбанк мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, инфляцийн хүлээлтийг зүй зохистой удирдахын тулд олон нийттэй харилцах харилцаандаа сүүлийн хугацаанд томоохон дэвшил гаргасан. Ил тод байдал болон хараат бус байдал нь харилцан биенээ дэмжих боломжтой үзүүлэлтүүд юм. Ил тод ажиллах зарчмын хүрээнд хараат бус байдлаа хангах боломжтой бол хараат бус байдлаа сайжруулснаар бодлогын тууштай байдал хангагдаж, эргээд олон нийттэй харилцах суваг илүү үр ашигт болох юм.

Төв банкны хараат бус байдал бидний амьдралд ямар нөлөөтэй вэ гэсэн асуултад дараах байдлаар хариулж болох юм. Засгийн газар хүүхдийн мөнгийг төв банкаар

дамжуулж олгох нь богино хугацаанд бидний амьдралд нэмэртэй мэт боловч урт хугацаандаа мөнгөний нийлүүлэлтийг удирдлагагүй болгож, цаашлаад худалдан авалтаар дамжуулж хэрэглээний бүтээгдэхүүний үнэ буюу инфляцийг өсгөх аюултай. 2012-2016 онд үнэ тогтворжуулах гэх мэт төсвийн шинжтэй олон хөтөлбөр хэрэгжиж байсан нь тухайн цаг үедээ эерэг дүр зургийг бий болгож байсан ч үнэн хэрэгтээ дараа дараагийн жилүүдэд ханшийг өсгөх, зах зээлийн зарчмыг алдагдуулах, тэгш бус байдлыг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг үүсгэсэн. Тиймээс төв банкны ил тод байдлыг сайжруулж, хараат бус байдлыг хуульчилж өгөх нь урт хугацаандаа эдийн засагт тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгоход эергээр нөлөөлдөг.





Л.ПҮРЭВДОРЖ: ЯМАР Ч НӨХЦӨЛД ТӨВ БАНК ХИЙХ ЁСТОЙ АЖЛЫНХАА ЖАНЖИН ШУГАМЫГ АЛДАХГҮЙ БАЙХ НЬ ЧУХАЛ



Монголбанкны Ерөнхийлөгч асан Л.Пүрэвдоржтой ярилцлаа.

Монгол Улсад банкны салбар үүсч, хөгжсөний 95 жилийн ой тохиож байна. Та Монголын банк, санхүүгийн салбарын өнөөгийн хөгжлийг хэрхэн дүгнэж байна вэ?

Монголын ард түмний сүүлийн 100 орчим жилийн хугацаанд буй болгосон их ололт, амжилтуудын нэг хэсэг нь банкны салбар юм. Монголчууд банк гэхээсээ илүү төлбөрийн хэрэгсэл, мөнгөн тэмдэгтийг ашиглаж байсан түүхийг харвал бүр Хүннүгийн үеэс яригдах байх. Харин яг банкны салбарын хувьд ардын засгийн үеэс эхлэн ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэн өнөө цагийг хүртэл хөгжлийг түүчээлсээр ирж, асар их ололт амжилтыг бий болгосон гэдэг нь хэнд ч эргэлзээгүй юм. Өнөөдөр ч бас Монголын эдийн засаг хэчнээн

бэрхшээлтэй, унаж, босож яваа ч банкны салбар Монголын эдийн засгийг авч явж, шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна. Ийм хамт олны 95 жилийн ойн баяр болж байна. Тийм учраас би юуны өмнө Монголбанк, Монголын банкны салбарын нийт хамт олонд 95 жилийн ойн баярын мэндийг хүргэж, түүхэн уламжлалаа хадгалж, улс орныхоо эдийн засгийг хөгжүүлэх бодлого, зорилтыг санхүү, эдийн засгийн талаас хангаж өгөх үүргээ амжилттай биелүүлнэ гэдэгт итгэж байгаагаа илэрхийлье.

Таныг төв банкны Ерөнхийлөгчөөр ажиллаж байх үед эдийн засгийн нөхцөл байдал ямар байв, түүнд тохируулсан мөнгөний бодлогыг хэрхэн хэрэгжүүлж байсан бэ?

Товчхондоо хэлэхэд мөнгөний бодлогод нэлээд шийдвэртэй алхмууд хийсэн. Ажлаа авснаас хойш хоёр сарын дараа бодлогын хүүг 4.25 хувиар огцом нэмэгдүүлж байлаа. Дараа нь валютын зах зээлд эрс шинэчлэлтийн алхмуудыг хэрэгжүүлж эхэлсэн. Валютын захад дуудлага худалдаагаар валют нийлүүлдэг болсон. Мөн гадаад валютын своп хэлцэл хийх гэх зэргээр мөнгөний бодлогын хүрээнд дөрвөн жилийн хугацаанд нэлээд шинэчлэл хийгдэж, үр дүнгээ өгсөн. Бид эдийн засгийн хямралыг маш богино хугацаанд давж, эдийн засгийн өндөр өсөлтөд хүрсэн. Намайг ажлаа авснаас хойших эхний жилүүдэд мөнгөний болон төсвийн бодлого хосолж, зөв чиглэлд явж чадсан. Харин сүүл рүүгээ эдийн засаг сайжрахын хэрээр төсвөөс асар их мөнгө зарлагдаж, бэлэн



мөнгө тарааж эхэлсэн. Энэ нь мөнгөний бодлогыг хүнд байдалд оруулснаар төв банкны зүгээс дунд хугацааны тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн халалт, инфляцийн өсөлтийг алдахгүйн тулд мөнгөний бодлогыг чангаруулсан. Ерөнхийд нь дүгнэвэл бид тухайн үед Монголын мөнгөний бодлого, валютын зах зээлийг шинэчлэх боловсронгуй болгох чиглэлд нэг алхам урагшилж чадсан гэж би хувьдаа бодож явдаг.

Цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бодлогын ямар асуудлуудыг та өөрийнхөө хувьд хэрэгжүүлж амжаагүй вэ?

Мэдээж бодлогын шинэчлэлийн алхмууд цаашид үргэлжилсэн. Бас нэг зүйлийг онцлоход банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор бид нэлээд шийдвэртэй алхам авч хэрэгжүүлсэн. Хоёр ч банкиг татан буулгасан. Тэгэхээс ч өөр арга байгаагүй. Тухайн үед банкуудын удирдлагын алдаанаас гадна макро эдийн засгийн бодлого, Монголбанкнаас авч хэрэгжүүлэх хяналтын бодлогод алдаа гарсантай холбоотой. Тийм учраас бид үүнээс сургамж авч, Банкны тухай хуулийг шинэчлэх, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, зохистой харьцааг хангуулах чиглэлээр бодлогын тодорхой арга хэмжээ авч, хэрэгжүүлж ирснийг хэлэх нь зүйтэй.

Ерөнхийдөө нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн бэ гэхээр 2012 оны үед гадаадын хөрөнгө оруулалт Монголоос зугтах хандлагатай болсон. Оюутолгойн хөрөнгө оруулалтын ид үе дууссан, дахин хөрөнгө оруулалт орж ирэх хугацаа нь болоогүй байсан. Мөн гадаад

зах зээл дээр түүхий эдийн үнэ буурах хандлагатай болчихсон байсан. Энэ үед юу чухал байсан бэ гэхээр мөнгөний бодлогыг хугацаа алдахгүйгээр нэлээд хатууруулах, төсвийн бодлогыг засах, банкны салбарын тогтвортой байдлыг хэрэгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх шаардлагатай байсан. Гэвч улс төрийн уур амьсгал үүний эсрэг чиглэлтэй байсан. Намууд сонгуульд оролцоходоо нэлээд том том амлалтууд өгсөн. Тухайн үед Ардчилсан нам сонгуульд ялсан. Улмаар мөнгөний болон төсвийн бодлогод нэлээд тэлсэн бодлого хэрэгжүүлэх шинжтэй болсон байдаг. Ингэж болохгүй гэдгийг би тухайн үед хэлж л байсан. Хэрвээ зөв бодлого явуулсан бол 2012 оноос эхлэлтэй эдийн засгийн хүндрэлийг хохирол багатайгаар богино хугацаанд даван туулах боломжтой байсан. Яах ёстой байсан бэ гэхээр өмнөх жилүүдэд бий болоод байсан эдийн засгийн өсөлт, төсвийн тэлсэн бодлогын хөөсрөлтийг маш богино хугацаанд шахаж, “хагалаад”, эдийн засгийн сууриа тогтворжуулах хэрэгтэй байсан. Эдийн засгийн сууриа тогтворжуулж аваад, цаашаа явсан бол тэгж ихээр валютын нөөцөө шавхаж, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшаа алдахгүй л байсан болов уу.

Тухайн үед олон улсын байгууллагууд ч бас энэ чиглэлийн зөвлөгөөг өгч байсан байх?

Олон улсын санхүүгийн байгууллагууд болон Монголбанкны мэргэжлийн хамт олон үүнийг харж л байсан. Өнөөдрийн бидний давж гарах гээд байгаа хүндрэлүүдийн

нэлээд хэсэг нь үндсэндээ бодлогын алдаанаас болж бий болсонд харамсаж явдаг.

Тийм учраас төв банкны хараат бус байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр цаашдаа ч анхаарах, хууль эрх зүйн хүрээний шинэчлэлийг тууштай үргэлжлүүлэх шаардлагатай байна. Төв банкны удирдлагыг улс төрөөс хараат бусаар ажиллах боломжийг хуулиар илүү баталгаажуулах чиглэлд онцгой анхаарах хэрэгтэй болов уу. Та энэ талаар ямар бодолтой байна вэ?

Хуулиар төв банкны Ерөнхийлөгч улс төрөөс хараат бусаар ажиллах боломж бүрэн бий. Өмнөх хуулиар ч бас боломжтой л байсан. Монголбанкны мэргэжлийн хамт олон зөв бодлого, зөв чиглэлийг гаргаж ирнэ гэдэгт би эргэлздэггүй. Гагцхүү төв банкны Ерөнхийлөгч хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх ёстой. Хуулийнхаа дагуу л ажиллах ёстой. Сонгууль дөхөж байна. Түүхий эдийн үнэ өсөх хандлагатай байна. Энэ үед Монголбанк руу чиглэсэн дайралт, шүүмжлэл, дарамт, шахалтууд ирнэ. Тэр бүхнээс үл хамааран Монголбанк яаж ажиллах ёстой вэ гэдэг чиг шугамандаа л зогсох ёстой. Монголбанкны Ерөнхийлөгчийн Монголын ард түмэн, Монголын эдийн засгийн өмнө хүлээсэн үүрэг нь “Ямар ч үед Монголбанкны хийх ёстой ажлыг л хийгээрэй. Түүнээс битгий хазайгаарай” л гэж байгаа юм. Монголбанкны хийх ёстой ажлыг чадлынхаа хэрээр хэрэгжүүл. Улс төр, төсвийн бодлого тогтворжиж, сахилга



баттай болно гэдэгт би итгэхгүй байна. Засгийн газраа дагаад төсөв яаж л өөрчлөгдөж болно. Ямар ч нөхцөлд Монголын эдийн засгийг хүнд байдалд оруулахгүй байх эцсийн найдвар нь Монголбанк л байх болно. Түүхэн хөгжлийн хугацаандаа ийм л байсан. Яг энэ жанжин шугамаа битгий алдаарай гэж Монголбанкны хамт олонд захимаар байна.

Түүнчлэн би Монголын банкны салбарын удирдлага, эздэд нэг зүйлийг захимаар байна. Монголын улс төр оновчтой байж чадахгүй. Улс төр нь эдийн засагтаа эрсдэл бий болгодог нь сүүлийн 20-оод жилийн хөгжлийн нүүр царай. Хэдийгээр Монголын эдийн засаг тодорхой мөчлөгтэй, гадаад зах зээл өсч, буурч байдаг хэдий ч тэр бүх хугацаанд улсын эдийн засгийг тогтвортой авч явах үүрэг улстөрчдөд бий. Гэвч Монголын улстөрчид багахан орлого олохоороо бүгдийг нь цацаад, хүндрэхээр юу ч үгүй сууж байдаг. Мэдэх мэдэхгүйгээр эдийн засаг руу хэт их оролцож, эрсдэл бий болгодог. Улмаар банк, санхүүгийн салбарт хүндрэл учруулдаг. Монголын эдийн засагт улс төрийн эрсдэл их учраас банкны салбар мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлмээр байна. Эдийн засаг өсч байх үед нэлээд болгоомжтой хандаж, дараагийн хүндрэл бий болоход даван туулах нөөцөө бүрдүүлж байх хэрэгтэй юм. Сонгууль ойртож байна. Монголын улс төр ойрын хэдэн жилдээ засагдаад, мундаг болчихно гэдэг найдвар маш бага харагдаж байна. Тийм учраас банкны салбар мөчлөг

сөрсөн бодлого хэрэгжүүлэх нь чухал шүү.

Бас нэг хэлэх гэсэн зүйл нь зээлийн хүү өндөр байгаа нь үнэн. Энэ нь Монголын аж ахуйн нэгж, иргэдэд учирч байгаа том дарамт мөн. Намайг ажил авч байх үед зээлийн хүү 23-24 хувь, зарим тохиолдолд 29 хувьтай байсан. Бид зөв бодлого хэрэгжүүлсний үр дүнд 14-15 хувь руу буурсан. Дараа нь зөв бодлого хэрэгжүүлж чадаагүй учраас эдийн засаг унаад, зээлийн хүү эргээд 20 хувьд хүрсэн. Сүүлийн 2-3 жилд зөв бодлого явуулсан учраас зээлийн хүү дахиад буурч эхэлж байна шүү дээ. Тэгэхээр зээлийн хүүг бууруулья гэвэл эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах ёстой. Тогтвортой өсөлтийг хангая гэвэл мөчлөг сөрсөн бодлого явуулах ёстой. Зээлийн хүү буурахгүй байгаа гол шалтгаан нь улс төрд байна. Улстөрчид бодлогын алдаа гаргаад байгаа учраас эдийн засаг савлаад, зээлийн хүүг өсгөөд байна. Тийм учраас өнөөдөр Монголбанк болон банкуудын хэрэгжүүлж буй бодлого дунд хугацааны тогтвортой байдлыг хадгалах, улмаар зээлийн хүүг бууруулах чиглэлтэй байх ёстой. Тэр өнцгөөр нь харвал өнөөдрийн Монголбанкны бодлогыг би зөв гэж харж байгаа. Гол шалтгаанаа олж харахгүйгээр зээлийн хүүг бууруулна гэдэг бол улстөржсөн, хий дэмий лоозонгоос хэтрэхгүй. Эдийн засаг тогтворжоод, хэлбэлзэл багатай байвал зээлийн хүү аажмаар буурах л ёстой. Мэдээж үүнээс гадна Монголбанкнаас хэрэгжүүлэх бодлогын нөлөө бий л дээ. Гэхдээ энэ нь голлох нөлөө биш юм.

Төв банк өнөөдөр үнийн тогтвортой байдлыг хангах ёстой. Гэвч хуулиар төв банкны үндсэн зорилтыг "төгрөгийн тогтвортой байдал" гэж томъёолоод, ханшийн тогтвортой байдлыг ч бас хангах ёстой гэж хандах тал бий. Төв банкны хуулийг өөрчлөхдөө хуулийн энэ хэсгийг "Үнийн тогтвортой байдал" гэж өөрчлөхийг зорьсон ч УИХ-аар дэмжигдээгүй. Улмаар улстөрчид төв банкнаас ханшийн тогтвортой байдлыг шаардах хандлага байсаар л байна. Үе үеийн Ерөнхийлөгч нарт улс төрөөс ирэх хамгийн том дарамт нь ханштай л холбогдож байсан болов уу. Ер нь ханш төв банкны хариуцах ёстой зүйл мөн үү?

Сүүлийн 2-3 жилд явж байгаа бодлогыг харахад валютын ханшийн талаар зөв бодлого баримталж байна гэж харж байгаа. Ерөнхийдөө ханш зах зээлийн зарчмаар өсөх, буурах трендийг хүлээн зөвшөөрөөд, бас хэт алдахгүйн тулд тэрбум орчим ам.долларын интервенц хийсэн байна. Үүнээс илүүгээр Монголбанк оролцож болохгүй. Үүнээс илүүгээр улс төр оролцож болохгүй. Хэрэв тэгэх юм бол дараагийнхаа уналтыг л бий болгосон хэрэг болно. Ер нь ямар ч нөхцөлд Монголбанк хийдэг ажлаа л хийх ёстой. Үүнээс болоод улс төр нь тэр хүнийг халах, солих бол дараагийн асуудал.

Ярилцсанд баярлалаа.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

МАРШАЛЫН ОДОН

БНМАУ-ЫН МАРШАЛЫН ОД

Он: 1979

Жин: 80 гр, голч: 6 см

“Маршалын од” нь шижир алт бөгөөд тал бүр тийшээ цацарсан таван хошуу хэлбэртэй юм. Таван хошууны төв дунд төрийн сүлдийг цагаан алтаар товойлгож дүрсэлсэн байна.

Одны хошууд хооронд 5 ширхэг очир алмаазыг цагаан алтаар хүрээлж шигтгэсэн. 14.5 грамм цагаан алт, 54.1 грамм шар алт, 4.9 карат очир алмаз чулуу оржээ.

Алтан бэхлэгээгээр гурвалжин алтан сэнжтэй холбогдож, түүнээс төрийн далбааны өнгөтэй 3.5 см-ийн өргөн торгон туузаар сүвлэсэн байна.





МОНГОЛ УЛСЫН БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ТУХАЙ ХЭН, ЮУ ХЭЛЭВ



УИХ-ын гишүүн Б.ЖАВХЛАН

Төв банкны бие даасан байдлыг ганц ерөнхийлөгчийн шийдвэр гаргах түвшинд ойлгож болохгүй. Манай нэг гаж тогтолцоо бол УИХ, төв банк хоорондын харилцаа. Ерөөсөө төв банкны ерөнхийлөгчийг улстөрчид дуудаж авчраад, ханш өндөр байна, тэд болго гэж загнаад л, валютын нөөцийг нь гаргаж ирээд, гэвчихдөг. Одоо жишээ нь зээлийн хүүг төв банкаар тогтоолгоно гээд л байна. Энэ бол зүгээр л хийрхсэн улс төр. Өөрөөр хэлбэл, энэ байдал яг хэвээрээ үргэлжлээд байх юм бол үндсэндээ бид 20 гаруй жил замнасан зах зээлээсээ ухарч, үнийг хүчээр тогтоодог төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг руугаа буцаж байгаас ялгаагүй. Одоо бол зээлийн хүүг бага байлгахыг хүсдэг олон нийтийн мөнхийн хүлээлт дээр улс төрийн тоглолд явагдах гээд байна. Энэ бол маш аюултай. Эцэст нь дахиад л иргэд хохирно. Төв банкныг бие даасан, хараат бус байлгана гэдгийн гол агуулга үүнд л байгаа юм. Улс төрөөс ангид байх хэрэгтэй байна.



Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.ЭРДЭМБИЛЭГ

Банкны салбарт хуримтлагдсан чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх нь банкнаас шинээр олгох зээлийн хэмжээг бууруулах, санхүүгийн зуучлалыг зогсонги байдалд оруулах, зээлийн үнэд сөргөөр нөлөөлөх, эдийн засгийн идэвхжилтийг сулруулах зэрэг олон сөрөг үр дагавартай. Иймд банк, санхүүгийн салбарт хуримтлагдсан чанаргүй активыг бууруулах, тус салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор хөрөнгийн удирдлагын мэргэшсэн институци байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг Монголбанк 2015 оноос эхлүүлсэн. Одоо энэ ажлын хүрээнд Актив удирдлагын тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барих бэлтгэл ажил хийж байна. Ийм мэргэшсэн институцийн үйл ажиллагааг идэвхжүүлснээр чанаргүй активыг түргэн хугацаанд шийдвэрлэх нөхцөл бүрдэх юм. Хуулиас гадна банкуудын чанаргүй зээлийг шийдвэрлэх чадамжийг нэмэгдүүлэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор өнгөрсөн 6 дугаар сард Чанаргүй зээлийг бууруулах стратегийг батлан, хэрэгжүүлж эхлээд байна.



Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.ЛХАГВАСҮРЭН

Зөвхөн бодлогын хүүгээр эдийн засгийг бүхэлд нь удирдах боломжгүй юм. Тийм учраас сүүлийн жилүүдэд олон улсын бусад төв банкны хувьд ч тэр жишиг болж буй макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг хэрэглэж эхэллээ. Эдийн засаг сэргэсэнтэй холбоотойгоор хэрэглээ нэмэгдэж, 2017 оны байдлаар банкны системээс гарч байгаа нийт зээлийн бараг 70-80 хувь нь хэрэглээний зээл болж өсөөд байв. Энэ нь хэрэглээг дэмжиж байгаа хэдий ч зээл бодит секторыг дэмжих, бизнес рүү гарах нь багассанаар сөрөг үр дагавар авчрах магадлалтай болсон билээ. Тийм учраас макро зохистой бодлогын хүрээнд хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг 60 хувиар тогтоох, хугацааны хувьд 30 сараар хязгаарлах бодлогын шийдвэрүүдийг гаргасан нь тодорхой үр дүнд хүрээд байна. Өнөөдрийн байдлаар банкны системээс гарч байгаа нийт зээлийн 30-40 хувь нь хэрэглээнд, 50-60 хувь нь бизнес рүү чиглэсэн нь энэхүү бодлогын үр дүн илэрч байгаа юм. .



ОУВС-ийн суурин төлөөлөгч НЭЙЛ САКЕР

Санхүүгийн салбар бол эдийн засгийг дэмжиж байх ёстой маш чухал салбарын нэг. Энэ салбарыг бэхжүүлэх нь ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн гол цөм юм. Арилжааны банкууд зөв зохистой хяналт шалгалттай, хангалттай хэмжээний өөрийн хөрөнгөтэй, эдийн засгийг дэмжих шаардлагатай зээлийн эх үүсвэрийг зах зээлд нийлүүлэх чадвартай, жижиг, дунд, шинээр үүсэж байгаа болон эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмждэг, зүйд нийцэх хэмжээний зээлийн хүүтэй байх ёстой. Өмнө нь арилжааны банкууд бараг зээл гаргахгүй, Засгийн газрын 18%-ийн хүүтэй үнэт цаасыг худалдаж авчихаад хий ашиг хийгээд сууж байсан бол Монголбанкны зүгээс тодорхой шаардлага тавьж эхэлсэн. Активын чанарын үнэлгээ (АЧҮ) гэдэг бол санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх цогц хөтөлбөрийн эхний алхам байв.



Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч ЖЯАН ПАСКАЛ НГАНУ

Активын чанарын үнэлгээ нь үнэндээ Монголын банкны салбарт эргэлтийн цэг байсан гэж хэлж болохоор байгаа юм Үнэлгээний үр дүн бусад орнуудтай харьцуулахад харьцангуй сайн гарсан нь эерэг мэдээ байсан. Тухайлбал, 1998 оны Азийн санхүүгийн хямралын үед Азийн орнуудын хийсэн AQR-ын үр дүн тийм ч сайн байгаагүй. Үнэлгээний үр дүнгээр банкуудын өөрийн хөрөнгийн дутагдал 2017 оны эцсийн байдлаар ДНБ-ий 1.9 хувьтай гарсан. ЗГ болон төв банкнаас өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш эдийн засгийн сэргэлт хурдтай явагдсан нь банкны салбарт нэлээд эерэг нөлөө үзүүллээ. Мөн хууль эрх зүйн орчинд нэлээд дорвитой шинэчлэл хийгдэж, банкны тухай болон төв банкны тухай хуулиуд засаглалын олон улсын стандартын дагуу шинэчлэгдээд байна. Гэвч сайжруулах шаардлагатай зүйлүүд байсаар байна.



АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгч ЁЛАНДА ФЕРНАНДЕЗ ЛОММЕН

Банкны болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгална гэдэг маш чухал. Банкны зээл өснө гэдэг нь нийт эрэлтээр дамжуулж эдийн засагт эерэг нөлөө үзүүлдэг. Гэхдээ хэт өсч, стандарт хэмжээнээс давах юм бол зээл нь эдийн засагт тогт воргүй байдлыг бий болгодог. Тиймээс олон улсын стандартыг мөрдөж, бусдаас сургамж авч ажиллах нь зүйтэй. Санхүүгийн харьцаануудыг санамсаргүйгээр тодорхойлдоггүй бөгөөд ихээхэн тооцоо, шинжилгээн дээр үндэслэж тогтоодог. Тиймээс хэрэглээний зээл хэт өсч, дунд болон урт хугацаанд асуудал үүсгэхгүй байх нь чухал. Төв банкны зүгээс зээлийн өсөлтийн түвшинг удирдлагадаа байлгаж, олон улсын зөвшөөрөгдсөн арга хэмжээнүүдийг авч байгаа нь зүйтэй юм.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

НАСАН ЦАГЛАШГҮЙ АЮУШ

Санскрит: Амитаюс

Түвэд: Цэвэгмэд

XIX-XX зуун

Занабазар сургууль хийц

Алт шармал гууль, цутгамал

Жин: 553.1 гр

14.1 x 9 x 7.2 см





МОНГОЛ УЛСЫН ЭРДЭНЭСИЙН САН

TREASURY FUND OF MONGOLIA



BANK OF MONGOLIA


Ардын засгийн газар Орос улстай хамтран Монголын Худалдаа ба аж үйлдвэрийн банк (Монголбанк)-ийг байгуулж, 1924 оны 6 дугаар сарын 2-ноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн билээ. Үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн анхны өдрөөс улсын эрдэнэсийн нөөцийг бүрдүүлж эхэлсэн байна. Эрдэнэсийн нөөцийг бүрдүүлэх хүрээнд иргэд болон албан байгууллагуудаас хосгүй үнэт эдлэлүүдийг хүлээн авч ирсэн юм. Улсын эрдэнэсийн нөөцийг арвижуулахад онцгой анхаарал тавьж ажилласны үр дүнд Монгол Улсын түүх, соёлын ховор нандин үнэт зүйлсийн баялаг цуглуулгатай болж, БНМАУ-ын Сайд нарын

зөвлөлийн 1983 оны 101 дүгээр тогтоолоор Улсын банкинд буюу Монголбанкинд "Үнэт зүйлс, эрдэнэсийн улсын фонд"-ыг тусгаарлан байгуулжээ.

Цаашлаад 1994 онд "Эрдэнэсийн сангийн тухай хууль" Улсын Их Хурлаар батлагдсан нь Улсын Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааг хуульчилж, түүний халдашгүй байдлыг баталгаажуулсан юм. Монгол Улсад банкны тогтолцоо үсч бэхэжсэний 80 жилийн тэмдэглэлт ойг тохиолдуулан "Эрдэнэсийн сангийн үзмэр"-ийг байгуулж, Эрдэнэсийн санд хадгалагдаж буй үнэт зүйлийн дээжээс олон нийтэд дэлгэн үзүүлэх боломж бүрджээ.

"Эрдэнэсийн сангийн үзмэр"-т Хүннү гүрний үеэс Чингис хааны үеийн түүхэн зооснууд, дурсгалын алт, мөнгөн зооснууд, Шашин төрийг хослон баригч Богд хааны алт, мөнгө, хаш тамга, манж, төвд, Хятадаас Богд хаанд ирүүлсэн алтан өргөмжлөлүүд зэрэг түүхийн хосгүй үнэт зүйлс болон түүхэн хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан үнэт эдлэл, монгол дархчуулын урласан ховор нандин эдлэл хэрэглэлүүдийг байрлуулсан байдаг.

2018 оны байдлаар Монгол Улсын Эрдэнэсийн сангийн эд зүйлсэд анх удаа олон улсын стандартын дагуу үнэлгээ хийлгэж, сан хөмрөгөө түүхийн хосгүй үнэт олдворуудаар баяжуулсан байна.





ДУРСГАЛ МӨНХЛӨХ ЗООС ЭРТНЭЭС ЭДҮГЭЭД

Монгол Улсын шинэ үеийн дурсгалын зоос хагас зуу орчим жилийн түүхэн уламжлалтай. Хүн төрөлхтний болон өөрийн орны түүхэн тэмдэглэлт ой, түүхт хүмүүс, соёлын өв, онцлог үйл явдал, соёл урлаг, спортын амжилтад зориулан, Монголбанк олон төрлийн дурсгалын зоос гаргажээ.

Дурсгалын зоосыг алт, мөнгө, цагаан алт зэргээс гадна зэс, никель, гууль зэрэг өнгөт төмөрлөгөөр хийсэн байна. Дурсгалын зоос нь тухайн үйл явдалд зориулсан зураг чимэглэл, тусгай бичвэртэй байдгаараа бусад зоосноос



ялгаатай. Монголбанк хамгийн анх 1971 онд Ардын хувьсгалын 50 жилийн ойд зориулан, нэг төгрөгийн нэрлэсэн үнэтэй алт, мөнгө, гууль, никель дурсгалын зоосыг анх гаргасан байдаг ба эдгээр зоосыг Герман улсын MDM зоосны үйлдвэрт захиалан хийлгүүлж байв.


Улс орон бүр түүхэн онцлог үйл явдалд зориулж дурсгалын зоос гаргадаг. Монгол Улс ч энэ жишгээр өвөрмөц загвартай, цөөн тоотой үнэт зоос үйлдвэрлүүлдэг нь ямагт эрэлт ихтэй байсаар байна.

Техник технологийн хөгжил дэвшил, урлан бүтээгчдийн чадвартай уялдан, манай улсын дурсгалын зоосны загвар, үзэмж жилээс жилд улам сайжирч, ур хийцийн хувьд дэлхийн түвшний хэмжээнд үнэлэгдэх болсон юм.





Тухайлбал, 2007 оны “Нохой зээх” зоос 2009 онд ХБНГУ-ын Берлин хотод болсон дэлхийн үзэсгэлэнгээс “Оны шилдэг зоос”, 2012 оны “Уралын шар шувуу” зоос мөн онд ОХУ-ын Москва хотод болсон олон улсын дурсгалын зоосны уралдаанаас “Оны шилдэг зоос”, 2013 онд ХБНГУ-ын Берлин хотод болсон дэлхийн үзэсгэлэнгээс “Хамгийн алдартай зоос” шагналыг тус тус хүртээд байна.



Эрдэнэсийн санд хадгалагдаж буй хамгийн үнэтэй дурсгалын зоосны хувьд БНМАУ-ыг тунхагласны 70 жилийн ойд зориулан бүтээлгэсэн Чингис хааны 1 килограммын алтан зоос юм.

Уг зоосны нүүрэн талд нь Чингис хааны хөрөг дүрийг товойлгон, баруун талд нь “Чингис хаан” гэж монгол бичгээр, доод талд нь англиар бичсэн. Зүүн талд оныг араб тоогоор тавьж, бадам хээгээр хүрээлсэн. Ар тал: Төв хэсэгт “Соёмбо” тэмдгийг товойлгон дүрсэлж, хоёр хажуу талд нь “Монгол”, “Улс” гэж монгол бичгээр, дээд талд нь “THE 70th ANNIVERSARY OF MONGOLIA”, “ONE KILO 9999 GOLD” гэж англиар, доод талд нь нэрлэсэн үнэ “250 000 төгрөг”, “1924”, “1994” оныг араб тоогоор тус тус бичсэн.

Монголбанк 2019 онд Банкны хөгжлийн 95 жилийн ойг тохиолдуулан “Монголбанк-95 жил” гэсэн хоёр цуврал мөнгөн зоос, мөн харагчин гахай жилд зориулсан “Монгол бодон” зэрэг дурсгалын мөнгөн зоосыг гаргаад байгаа билээ.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

БОГД ХААНД ӨРГӨСӨН
АЛТАН НАВЧИТ ӨРГӨМЖЛӨЛ

Хосгүй үнэт

1915 он

Жин: 11235.0 гр

22.5 x 9.3 см

17 алтан хуудас



Богд хаанд ламын алтан тамгын хамт энэхүү алтан навчит өргөмжлөлийг билгийн тооллын 1915 оны хаврын сүүл сарын арван нэгэнд өргөн барьжээ. Өргөмжлөлийн үгийг алтан хуудас дээр монгол, түвэд хэлээр сийлэн бичиж улаан шунхаар тодруулжээ.

Алтан навчит өргөмжлөлийн монгол бичгийн сийрүүлгээс...

"Шашин төрийг хослон баригч, Наран гэрэлт түмэн наст Богд эзэн хааны зарлиг, Би тэнгэрийн цагийг дагаж, төр шашныг хослон барьж Монгол улсыг жолоодон тогтоохуй дор үнэнээр тус хийж чадагчдыг хэтэрхийээ эрхэмлэх бөгөөд, эн тэргүүн өргөмжилбөөс зохих Жавзандамба лам болбоос эртний Мин улсын цаг Их Юань улсын

Тайцу хааны үе, Халхын Очирай бат Түшээт сайн хан Гомбодоржийн гэрт хувилгаан гарч, бурханы шашныг дэлгэрүүлэн, хамаг амьтныг гийгүүлж, Халхын олон монголчуудыг тэргүүлэн авч, манж монголыг найралдуулан, гавьяа байгуулсан учирт, умар зүгийн амьтны итгэл, номын Богд хэмээн алтан тамга, алтан навчит өргөмжлөлийн зэрэг зүйл бүр ёслолын юм шагнагдаж, Манж эзэн лугаа нэгэн суурин дор суух зэргээр маш өргөмжлөгдсөн анхан төрлийн Өндөр Богдоос эхлэн төрөл тутам бэлгэ билэг лүгээ төгөлдөр судар тарнийн шашныг мандуулж, амьтныг жаргуулсан тус эрдэм зарлигийн ач хязгаарлашгүй буй..."





ШАШИН ТӨРИЙГ
ХОСЛОН БАРИГЧ НАРАНГЭРЭЛТ
БОГД ХААНЫ МӨНГӨН ТАМГА

ХОСГУЙ ҮНЭТ

1911 он

Жин: 5890 гр

Өндөр: 12.5 см, 11.7 x 11.7 см

Зузаан: 3.3 см

Мөнгө, цутгамал